



# **ОЛИМПИЙН ХАРТИ**

2003 оны долдугаар сарын 4-нөөс даган  
мөрдөж байна

**Олон Улсын Олимпийн Хороо**

# **Олимпийн Харти**

## **Гарчиг**

### **Үндсэн зарчмууд**

#### **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

##### **Олимпийн хөдөлгөөн**

1. Эрх барих дээд байгууллага
2. ОУОХ-ны гүйцэтгэх үүрэг
3. Олимпийн хөдөлгөөнд хамаарагдах нь
4. ОУОХ-ноос хүлээн зөвшөөрөх нь
5. ОУОХ-ны ивээл
6. Олон улсын спортын холбоод болон Үндэсний олимпийн хороодтой тогтмол зөвлөлдөх нь
7. Олимпийн их хурал
8. Олимпийн эв санааны нэгдэл\*
9. Олимпийн наадам
10. Олимпиад
11. Олимпийн наадмын талаар эдлэх эрх
12. Олимпийн билгэдэл\*
13. Олимпийн далбаа\*
14. Олимпийн уриа\*
15. Олимпийн онцлох тэмдэг\*
16. Олимпийн дуулал\*
17. Олимпийн билгэдэл, далбаа, уриа, онцлох тэмдэг, дууллын талаар эдлэх эрх
18. Олимпийн гал, олимпийн бамбар

#### **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

##### **Олон улсын олимпийн хороо (ОУОХ)**

19. Хууль ёсны эрх хэмжээ
20. Гишүүд
  1. ОУОХ-ны бүрэлдэхүүн - ОУОХ-нд шинэ гишүүн элсүүлэх, сонгох, батлах, эрх хэмжээг нь тодорхойлох
  2. Үүрэг
  3. ОУОХ-ны гишүүн байх эрхээ алдах нь
  4. Насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч - хүндэт гишүүд - өргөмжлөлт гишүүд
  5. Гишүүдийн нэрсийн жагсаалт
21. ОУОХ-ны зохион байгуулалт
22. Чуулган
23. Гүйцэтгэх Зөвлөл
  1. Бүрэлдэхүүн
  2. Сонгууль
  3. Бүрэн эрхийн хугацаа, түүнийг шинэчлэх нь
  4. Сул орон тоо
  5. Бүрэн эрх, үүрэг
24. Ерөнхийлөгч
25. ОУОХ-ны Ёс зүйн комиссоос авах арга хэмжээ ба хориг тавих

26. Чуулганы дэг журам
  1. Ердийн журам
  2. Яаралтай үед мөрдөх журам
27. Албан ёсны хэл
28. ОУОХ-ны хөрөнгө санхүү

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### ***Олон улсын спортын холбоод (ОУСХ-оод)***

29. ОУСХ-дыг хүлээн зөвшөөрөх нь
30. ОУСХ-дын үүрэг

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ**

### ***Үндэсний Олимпийн Хороод (ҮОХ-оод)***

31. ҮОХ-дын үүрэг зорилго
32. ҮОХ-дын бүрэлдэхүүн\*
33. Үндэсний спортын холбоод
34. Улс ба ҮОХ-дын нэр
35. Далбаа, онцлох тэмдэг, дуулал

## **ТАВДУГААР БҮЛЭГ**

### ***Олимпийн наадам***

#### ***I. Олимпийн наадмын зохион байгуулалт, удирдлага***

36. Олимпийн наадмыг тэмдэглэх нь
37. Олимпийн наадам зохион байгуулах хотыг сонгон шалгаруулах нь\*
38. Олимпийн наадмыг зохион явуулах газар
39. Зохион байгуулах хороо
40. Хариуцлага
41. ҮОХ, ЗБХ-ны хоорондох харилцаа\* Атташе
  1. Төлөөлөгчдийн тэргүүн
  2. Зохицуулах комисс
42. Олимпийн тосгон\*
43. Олимпийн наадмын хөтөлбөрт орсон спортын төрлүүдийг эрхлэн удирдаж буй ОУСХ-дод үзүүлэх дэмжлэг
44. Соёлын хөтөлбөр\*

#### ***II. Олимпийн наадамд оролцох нь***

45. Наадамд оролцуулах журам\*
46. Оролцогчдын иргэний харъяалал\*
47. Насны хязгаар
48. Сэргээшийн эсрэг олон улсын дүрэм ба Эмнэлгийн комисс
49. Мэдүүлэг\*
50. Олимпийн Хартийг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ

### **III. Олимпийн наадмын хөтөлбөр**

51. Олимпийн наадмын спортын төрлүүд
  1. Зуны Олимпийн наадам
  2. Өвлийн Олимпийн наадам
52. Олимпийн наадмын хөтөлбөрт орох спортын төрөл , түүний салбарласан төрөл /жин, зай гэх мэт/, тэмцээний төрөл
  1. Олимпийн наадмын хөтөлбөрт орох спортын төрлүүд
  2. Спортын салбарласан төрлүүд /жин, зай гэх мэт/
  3. Уралдаан тэмцээний төрөл
  4. Спортын төрөл, салбарласан төрөл /жин , зай гэх мэт/, мөн уралдаан тэмцээний төрөлд тавих шаардлага
  5. ОУСХ-доос Олимпийн наадамд оролцох тухай мэдүүлэх нь
  6. Олимпийн наадмын хөтөлбөрт спортын салбарласан төрөл /жин, зай г.м/, мөн уралдаан тэмцээний төрлийг жич оруулах нь
  7. Хөтөлбөрт спортын төрөл, түүний салбарласан төрөл /жин, зай гэх мэт/ , мөн уралдаан тэмцээний төрлийг оруулах эсвэл хасах эрх мэдэл
53. Олимпийн наадмын хөтөлбөр
54. ОУСХ-доос зохион байгуулах сонгон шалгаруулалтын уралдаан тэмцээн
55. Олимпийн наадмыг ЗБХ-ноос явуулж буй Олимпийн өмнөх тэмцээнүүд
56. Олимпийн наадамд оролцох нь\*
57. Техникийн зохицуулалт\*
58. Залуучуудын зуслан
59. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Олимпийн наадмыг сурталчлах нь\*
60. Хэвлэл мэдээлэл
61. Зар сурталчилгаа\*
62. Хөгжмийн бүтээл\*
63. Олимпийн наадмыг ЗБХ-ноос Олимпийн өмнө явуулах арилжааны зар сурталчилгаа

### **IV. Ёслолын ажиллагаа**

64. Урилга\*
65. Олимпийн наадамд оролцох үнэмлэх, нэвтрэх карт
66. Олимпийн үнэмлэх, нэвтрэх карт эзэмшигчийн эрх
67. Олимпийн далбааг мандуулах нь
68. Олимпийн галыг бадраах нь
69. Нээлт, хаалтын ёслол\*
70. Шагнал гардуулах ёслол, медаль, дипломууд\*
71. Шагналтнуудын нэрсийн жагсаалт
72. Протокол
73. Ёслолын хөтөлбөр

### **V. Арбитрын шүүх**

74. Арбитрын шүүхийн ажиллагаа

\*Ийм тэмдэг бүхий Заалтууд нь нэмэлт албан ёсны тайлбартай юм.

**Олимпийн Харти хамгийн сүүлд нийтлэгдэж гарснаас хойш (2001 оны 7 дугаар сарын 14-нөөс мөрдөгдөж байсан) түүнд дараах өөрчлөлт оруулсан байна. Үүнд:**

- Мехико хотноо 2002 оны 11 дүгээр сарын 29-нд болсон ОУОХ-ны 114 дүгээр Чуулганаар баталсан нь:
  - Хартийн 2-ын 13 дугаар зүйл (ОУОХ-ны үүрэг)
  - Хартийн 20-ын 1.1, 3.2, 3.4.2, 5-р заалтууд, мөн тайлбарын 1.2, 2.2.2, 2.7, 2.8.7-р заалтууд (Гишүүд)
  - Хартийн 23-ын 1-р зүйл, 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5, 4.1, 4.2-р заалтууд (Гүйцэтгэх Зөвлөл)
  - Хартийн 32-ын 1.1-р заалт (Үндэсний Олимпийн Хороодын бүрэлдэхүүн)
  - Хартийн 42-ын 1-р зүйл (Олимпийн тосгон)
  - Хартийн 60-р зүйл (Хэвлэл мэдээлэл)
- Прага хотноо 2003 оны 7 дугаар сарын 4-нд болсон ОУОХ-ны 115 дугаар Чуулганаар өөрчилж баталсан нь:
  - Хартийн 25-ын 2-р зүйл, 2.2.1, 2.2.4, 2.2.5-р заалтууд болон 5-р зүйл (ОУОХ-ны Ёс зүйн комиссоос авах арга хэмжээ, хүлээлгэх шийтгэл)
  - Хартийн 29-д (Олон улсын спортын холбоодыг хүлээн зөвшөөрөх нь)
  - Хартийн 45-д болон түүний тайлбарын 3-р зүйл (Наадамд оролцуулах журам)
  - Хартийн 48-ын 1-р зүйл, 2.1, 2.1.1 болон 2.2-р заалтууд (Сэргээшийн эсрэг олон улсын дүрэм ба Эмнэлгийн комисс)
  - Хартийн 49-ын тайлбарын 3-р зүйл, 5.1 болон 5.3-р заалтууд (Мэдүүлэг)
  - Хартийн 52-ын 1.1.3-р заалт (Спортын хөтөлбөр, спортын төрөл, түүний салбарласан төрөл, уралдаан тэмцээний төрөл)
  - Хартийн 50-р зүйл (Олимпийн Хартийн зөрчил)
  - Хартийн 70-р зүйлийн тайлбарын 2.4-р заалт (Шагнал гардуулах ёслол, медаль, дипломууд)

**Жич тайлбар:**

Олимпийн Хартид нэр үг болон төлөөний нэр үг хэрэглэхдээ гишүүн, удирдагч, албаны хүн, төлөөлөгчдийн тэргүүн, оролцогч, өрсөлдөгч, тамирчин, шүүгч, шүүгчдийн зөвлөлийн гишүүн, атташе, нэр дэвшигч, ажилтан гэх зэрэг, мөн тэр, тэд, тэдэнд гэх мэт зөвхөн эр хүйсээр төлөөлөн хэлсэн нь эсрэг хүйстэнг нарийн тодорхойлох тусгай заалт байхгүй бол түүнд эмэгтэйчүүдийг бас хамруулж байна гэж ойлгох хэрэгтэй.

## Үндсэн зарчмууд

1. Орчин үеийн олимпизмийн үзэл санааг үндэслэгч Пьер де Кубертин бөгөөд түүний санаачлагаар 1894 оны 6 дугаар сард Парис хотноо Олон улсын Тамирчдын их хурал болсон байна. Олон улсын олимпийн хороо 1894 оны 6 дугаар сарын 23-нд байгуулагдснаа зарласан билээ. Үүнээс хойш зуун жилийн дараа 1994 оны 8 дугаар сард Парис хотноо Олимпийн XII их хурал хуралдсан нь “Эв нэгдлийн их хурал” гэж нэрлэгдсэн ажээ.
2. Олимпизм бол хүний бие бялдар, хүсэл зориг, оюун ухааныг дээдэлсэн эрхэм зорилго бүхий амьдралын гүн ухаан юм. Олимпизм нь спортыг соёл, боловсролтой нэгтгэн, хичээнгүй зүтгэлийн үр дүн болсон баяр баясгалан хийгээд сайн үлгэр дууриаллын хүмүүжүүлэх үнэт чанар, ёс зүйн түгээмэл үндсэн зарчмуудыг хүндэтгэх явдалд тулгуурласан сайн сайхан аж төрөх ёсыг төлөвшүүлэхийг эрмэлзэнэ.
3. Олимпизмийн зорилго бол хүний эрхэм чанарыг хадгалахад санаа тавих энх амгалан нийгэм байгуулахад тус дэм болох үүднээс спортыг хүний өв тэгш хөгжлийн төлөө үйлчлэхэд чиглүүлэх явдал даруй мөн. Иймээс Олимпийн хөдөлгөөн нь дангаараа эсвэл бусад байгууллагуудтай хамтран ажиллаж өөрийн арга хэрэгслийнхээ хүрээнд энх тайвныг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулна .
4. ОУОХ-гоор удирдуулсан Олимпийн хөдөлгөөн нь орчин үеийн олимпизмаас үүсэл гаралтай юм.
5. Олимпийн хөдөлгөөн нь Олимпийн Хартийг мөрдөхийг хүлээн зөвшөөрсөн байгууллага, тамирчид, бусад хүмүүсийг ОУОХ-ны удирдлагын дор нэгтгэн чиглүүлж байдаг. Олимпийн хөдөлгөөнд хамрагдах шалгуур нь ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлэх явдал юм. Спортын зохион байгуулалт удирдлагыг, бие даасан хүлээн зөвшөөрөгдсөн спортын байгууллагууд хэрэгжүүлэх ёстой.
6. Олимпийн хөдөлгөөний зорилго нь харилцан ойлголцох, үнэнч шударга тоглолт, энх тайван, эв санааны нэгдэлтэй байх олимпийн зарчмыг баримтлан спортод аливаа нэгэн ялгаварлан гадуурхах зүйлгүй байж, спортын хэрэглэгдэхүүнээр залуучуудыг хүмүүжүүлэх замаар сайн сайхан нийгмийг байгуулахад оршино.
7. Хэлхээтэй таван цагаригаар билгэдсэн Олимпийн хөдөлгөөний үйл ажиллагаа нь байнгын, түгээмэл шинж чанартай бөгөөд таван тивийг хамарч, түүний оргил спортын их баяр болох Олимпийн наадамд дэлхийн тамирчдыг нэгтгэн оролцуулах явдал билээ.
8. Спортоор хичээллэх нь хүний нэг эрх мөн. Хүн бүр өөрийн хэрэгцээнийхээ дагуу спортоор хичээллэх бололцоогоор хангагдсан байх ёстой.
9. Олимпийн Харти нь ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг зарчмууд, заалт ба албан ёсны тайлбарыг нэгтгэсэн хууль мөн. Энэхүү хууль нь

Олимпийн хөдөлгөөнийг зохион байгуулах, үйл ажиллагааг нь хэрэгжүүлэх, Олимпийн наадмыг зохион явуулах нөхцлийг бүрдүүлж өгнө.

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ**

### ***олимпийн хөдөлгөөн***

#### **Нэг. Эрх барих дээд байгууллага**

1. ОУОХ бол олимпийн хөдөлгөөний эрх барих дээд байгууллага мөн.
2. Олимпийн хөдөлгөөнд ямар нэг байдлаар хамааралтай бие хүн эсвэл байгууллага нь Олимпийн Хартийн заалтыг заавал мөрдөж ОУОХ-ны шийдвэрийг тууштай баримтална.

#### **Хоёр. ОУОХ-ны гүйцэтгэх үүрэг**

ОУОХ Олимпийн Хартийн дагуу олимпизмийг хөгжүүлэн удирдах үүрэг хүлээнэ. Үүний тулд ОУОХ:

1. Спорт болон спортын уралдаан тэмцээний зохицуулалт, зохион байгуулалт, хөгжилд тусалж, олон улсын ба үндэсний спортын байгууллагуудтай уялдаа холбоотой ажиллан олимпийн хөдөлгөөний эв нэгдлийг бэхжүүлэхэд чиглэгдсэн арга хэмжээнүүдийг дэмжиж хэрэгжүүлнэ;
2. Спортыг хүн төрөлхтний эрх ашигт нийцүүлэн хөгжүүлэх эрмэлзлэл, эрх мэдэл бүхий төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийнхэнтэй хамтран ажиллах
3. Олимпийн наадмыг тогтмол зохион явуулах нөхцлийг бүрдүүлнэ ;
4. Энх тайвныг бэхжүүлэх арга хэмжээнд оролцож олимпийн хөдөлгөөний гишүүдийн эрхийг хамгаалах, мөн олимпийн хөдөлгөөнд муугаар нөлөөлөх ялгаварлан гадуурхах аливаа хэлбэрийн эсрэг тэмцэх үйл ажиллагаа явуулна;
5. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдлын зарчмыг хатуу баримтлах үүднээс спортын бүх түвшинд, бүтцийн бүх хүрээнд, нэн ялангуяа үндэсний болон олон улсын спортын байгууллагуудад эмэгтэйчүүдийг өргөнөөр оролцуулах явдлыг зохих арга хэрэгслээр идэвхтэй дэмжинэ;
6. Спортын ёс зүйг мөрдөхийг хөхүүлэн дэмжинэ;
7. Спортын талбарт үнэнч шударга тоглолт давамгайлах, хүчирхийлэл гаргуулахгүй байхын төлөө чармайн ажиллана;

8. Спортод сэргээшийн эсрэг тэмцлийг удирдаж, ийм үйлчилгээ бүхий эм бодисыг хэрэглүүлэхгүй байх олон улсын үйл ажиллагаанд нэгдэн оролцоно;
9. Тамирчдын эрүүл мэндэд аюул учруулахгүй байх зорилго бүхий арга хэмжээ авах
10. Спорт болон тамирчдыг улс төр, арилжааны зорилгоор буруугаар ашиглах аливаа оролдлогын эсрэг тэмцэнэ;
11. Тамирчдын нийгмийн ба мэргэжлийн ирээдүйн сайн сайхны төлөө спортын болон улсын байгууллагын хүчин чармайлтыг дэмжинэ;
12. Их спортын үндэс суурийн нэг хэсэг болох нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхийг дэмжинэ. Их спорт нь эргээд бас нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд тус дөхөм болдог.
13. Олимпийн наадам нь Олимпийн наадмыг зохион байгуулагч хот, улс оронд эерэг үр өгөөжтэй байх арга хэмжээ авна. Үүнд: Олимпийн наадмын цар хүрээ, зардалд зохих хяналт тавих, мөн Олимпийн наадмыг зохион байгуулах хороо (ЗБХ), Олимпийн наадмыг зохион байгуулагч улс орон, түүний засаг захиргааны байгууллагууд, Олимпийн хөдөлгөөнд хамрагдах хүмүүс, байгууллагуудыг энэ журмын дагуу ажиллахыг дэмжинэ;
14. Олимпийн наадмыг байгаль орчны асуудалд нийцэхүйц нөхцөл байдалд зохион явуулахад хяналт тавина, мөн олимпийн хөдөлгөөнөөс байгаль орчныг хамгаалахад санаа тавьж ажиллахыг дэмжиж үүнийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлнэ, олимпийн хөдөлгөөнд хамрагдсан бүх хүмүүсийн дунд энэ салбарт өргөн хамтран ажиллах талаар ухуулан таниулах ажил зохионо;
15. Олон улсын олимпийн академид (ОУОА) дэмжлэг үзүүлнэ;
16. Олимпийн боловсролын чиглэлээр ажиллаж байгаа бусад байгууллагуудыг дэмжинэ.

### **Гурав. Олимпийн хөдөлгөөнд хамаарагдах нь**

1. Олимпийн хөдөлгөөнд ОУОХ-ноос гадна Олон улсын спортын холбоод (ОУСХ), Үндэсний олимпийн хороод (ҮОХ), Олимпийн наадмыг зохион байгуулах хороод (ЗБХ), үндэсний спортын холбоод, клубүүд, тэдгээрт харъяалагдах хүмүүс, тамирчид, шүүгчид, дасгалжуулагчид, спортын мэргэжлийн бусад хүмүүс хамаарагдана. Түүнчлэн ОУОХ-ноос хүлээн зөвшөөрсөн бусад байгууллага үүнд багтана.
2. Арьс өнгө, шашин шүтлэг, улс төр, хүйс болон өөр бусад шалтгааны улмаас улс орон эсвэл хувь хүнийг ялгаварлан гадуурхах аливаа хэлбэр нь олимпийн хөдөлгөөнд үл нийцнэ.

3. Олимпийн хөдөлгөөнд хамаарагдахын тулд ёс зүйн үндсэн зарчмуудыг хүндэтгэн дагах шаардлагатай юм.

**Дөрөв. ОУОХ-ноос хүлээн зөвшөөрөх нь**

1. Олимпийн хөдөлгөөнийг дэлхий нийтэд хөгжүүлэхийн тулд ОУОХ өөрийн үүрэгтэй уялдаа холбоо бүхий үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг Үндэсний Олимпийн Хороод гэж хүлээн зөвшөөрч болох юм. Эдгээр байгууллага нь боломжтой бол өөрийн улс оронд хуулийн этгээдийн эрхтэй байж болно. Ийм байгууллагууд нь Олимпийн Хартийн дагуу байгуулагдсан, ОУОХ-гоор дүрмээ батлуулсан байх ёстой.
2. ОУОХ нь ҮОХ-дыг тивийн буюу дэлхийн түвшинд нэгтгэсэн дараах холбоодыг хүлээн зөвшөөрч болно. Үүнд:
  - Үндэсний олимпийн хороодын холбоо (ANOC);
  - Африкийн Үндэсний олимпийн хороодын холбоо (ANOCA);
  - Азийн олимпийн зөвлөл (OCA);
  - Пан-Америкийн спортын байгууллага (PASO);
  - Далайн орнуудын Үндэсний олимпийн хороод (ONOC);
  - Европын олимпийн хороод (EOC);

Эдгээр байгууллагын дүрэм нь Олимпийн Хартид нийцэж, ОУОХ-оор батлагдсан байх ёстой.
3. Хартийн 29-т заагдсан нөхцлийн дагуу ОУСХ-дыг хүлээн зөвшөөрнө. Түүнчлэн ОУСХ-дыг нэгтгэсэн дараах байгууллагуудыг хүлээн зөвшөөрч болно. Үүнд:
  - Зуны Олимпийн олон улсын холбоодын нэгдэл (ASOIF);
  - Өвлийн Олимпийн олон улсын спортын холбоодын нэгдэл (AIOWF);
  - ОУОХ-ноос хүлээн зөвшөөрсөн олон улсын спортын холбоодын нэгдэл (ARISF);
  - Олон улсын спортын холбоодын ерөнхий нэгдэл (GAISF);
4. Олон улсын спортын холбоодын нэгдлүүд эсвэл ҮОХ-дын холбоодыг хүлээн зөвшөөрөх явдал нь тус тус ОУСХ болон ҮОХ-ны ОУОХ-той шууд харилцах, мөн ОУОХ-ноос тэдгээртэй шууд харилцах эрхэнд ямар ч нөлөөгүй байна.
5. ОУОХ спортод хамааралтай, үйл ажиллагаагаа Олимпийн Хартид нийцэхүйц олон улсын түвшинд явуулж буй төрийн бус байгууллагуудыг хүлээн зөвшөөрч болно.
6. ОУОХ-ноос ОУСХолбоод, ҮОХороод болон бусад байгууллагуудыг хүлээн зөвшөөрснөө цуцалж болох бөгөөд энэ шийдвэр нь нэн даруй хүчин төгөлдөр болно.

### **Тав. ОУОХ-ны ивээл**

1. ОУОХ спортын олон төрлийг хамарсан олон улсын, бүсийн, тивийн болон дэлхийн хэмжээний тэмцээнийг зохих нөхцөл болзлын дагуу өөрийн ивээлд авч болно. Ингэхдээ эдгээр тэмцээнийг Олимпийн Хартид нягт нийцүүлж ОУОХ-ноос хүлээн зөвшөөрсөн ҮОХороод эсвэл тэдгээрийг нэгтгэсэн холбоодын хяналтын дор зохих ОУСХ-дын техникийн дүрмийн дагуу, тэдний туслалцаатай зохион явуулах болзолтой байна.
2. Түүнчлэн ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нь олимпийн хөдөлгөөний зорилгод нийцсэн бусад арга хэмжээг ОУОХ-ны ивээлд авах асуудлыг шийдвэрлэж болно.

### **Зургаа. Олон улсын спортын холбоод болон Үндэсний олимпийн хороодтой тогтмол зөвлөлдөх нь**

ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл Олон улсын спортын холбоод болон Үндэсний олимпийн хороодтой хоёр жилд нэгээс доошгүй уулзалт зохион байгуулна. Уг уулзалтыг ОУОХ-ны Ерөнхийлөгч удирдах бөгөөд хэлэлцэх асуудал, дэг журмыг нь холбогдох байгууллагуудтай зөвлөлдсөний үндсэн дээр тодорхойлно.

### **Долоо. Олимпийн их хурал**

1. ОУОХ олимпийн их хурлыг зарчмын хувьд найман жилд нэг удаа ОУОХ, түүний ерөнхийлөгчийн шийдвэрээр зарлан хуралдуулна. Их хурлын хуралдах газар, хугацааны товыг ОУОХороо тогтооно. ОУОХ-ны ерөнхийлөгч Олимпийн их хурлыг даргалах бөгөөд дэгийн дагуу асуудлыг хэлэлцүүлж шийдвэрлэнэ. Олимпийн их хурал нь зөвлөлдөх шинж чанартай явагдана.
2. Олимпийн их хурал нь ОУОХ-ны гишүүд, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүд, өргөмжлөлт гишүүд, ОУСХолбоод, ҮОХороод, ОУОХ-ноос хүлээн зөвшөөрсөн бусад байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Түүнээс гадна олимпийн их хуралд хувь хүн бие дааж эсвэл зохих байгууллагыг төлөөлж тамирчид, бусад хүмүүс урилгаар оролцоно.
3. ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл ОУСХолбоод, ҮОХороодтой зөвлөлдсөний дараа Олимпийн их хурлаар хэлэлцэх асуудлыг тодорхойлно.

### **Найм. Олимпийн эв санааны нэгдэл\***

1. Олимпийн эв санааны нэгдлийн зорилго бол ОУОХ-ноос хүлээн зөвшөөрсөн ҮОХ-дод, ялангуяа дэмжлэг авах шаардлагатай ҮОХ-дод тусламж үзүүлэх явдал юм. Ийм тусламжийг ОУОХ болон ҮОХ-дын хамтран боловсруулсан хөтөлбөрийн хэлбэрээр, шаардлагатай бол ОУСХ-доос техникийн туслалцаа авч хэрэгжүүлнэ.
2. Эдгээр бүх хөтөлбөрийг ОУОХ-ны Ерөнхийлөгчийн тэргүүлсэн Олимпийн эв санааны нэгдлийн комисс удирдан хэрэгжүүлнэ.

## **Хартийн 8-д өгөх албан ёсны тайлбар**

“Олимпийн эв санааны нэгдэл”-ээс боловсруулсан хөтөлбөр нь:

1. Олимпийн хөдөлгөөний үндсэн зарчмуудыг сурталчлах;
2. Тамирчид, дасгалжуулагчдын спорт, техникийн мэдлэгийг дээшлүүлэх;
3. Тэтгэлэг олгох замаар тамирчид, дасгалжуулагчдын техникийн түвшинг дээшлүүлэх;
4. Спортын болон захиргааны ажилтнуудыг бэлтгэх
5. Тодорхой чиглэсэн зорилготой олимпийн боловсрол, спортын сургалт сурталчилгааны талаар ажиллаж байгаа ОУОХ-ны янз бүрийн комисс болон нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах;
6. Шаардлагатай газарт энгийн, ажлын хэрэгцээ хангахуйц, зардлын хувьд хямд төсөр барилга байгууламжийг үндэсний эсвэл олон улсын байгууллагуудтай хамтран байгуулах;
7. ҮОХ-дын удирдлага, ивээлийн дор үндэсний, бүсийн, тивийн хэмжээний уралдаан тэмцээнийг зохион байгуулах;
8. ҮОХ-дын хооронд хоёр талын болон олон талын хамтын ажиллагааны хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
9. Хөгжлийн албан ёсны тусламжийн хөтөлбөрт спортыг оруулахын тулд засгийн газрын болон олон улсын байгууллагуудад нөлөө үзүүлэх зорилготой байна.

### **Ес. Олимпийн наадам**

1. Олимпийн наадам бол улс орнуудын хооронд биш харин тамирчдын дунд зохиогдох ганцаарчилсан эсвэл багуудын уралдаан тэмцээн юм. Харьяалсан ҮОХ-доос ийм зорилгоор сонгож авсан, мэдүүлгийг нь ОУОХ хүлээн авч зөвшөөрсөн тамирчид Олимпийн наадамд хуран цугларах ба тэд холбогдох ОУСХ-дын техникийн удирдамжийн дагуу спортынхоо төрөлд өрсөлдөнө.
2. ОУОХ Олимпийн наадамтай холбогдсон аливаа асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх мэдэлтэй байна.
3. Олимпийн наадам нь зуны болон өвлийн Олимпийн наадмаас бүрдэнэ. Зуны, өвлийн олимпийн наадмыг тус тусад нь дөрвөн жил тутамд доорх 4-р зүйлийн заалтын дагуу зохион явуулна.
4. Анхны өвлийн Олимпийн наадам нь 1924 онд болж энэ үеэс хойш тэр дэс дараалалаар зохион байгуулагдаж ирсэн. Харин өвлийн Олимпийн ХҮИИ наадам

нь 1994 онд болсон. Мөс, цасан дээр явагдах спортын төрлүүдийг өвлийн спортын төрлүүд хэмээн үздэг байна.

### **Арав. Олимпиад**

1. “Олимпиад” гэсэн нэр томъёо нь Олимпийн наадам эхэлсэн өдрөөс дараагийн олимпийн наадам эхлэх өдөр хүртэлх хугацаанд үргэлжлэх дөрвөн жилийн дараалалтай нэг үеийг хэлнэ.
2. Ээлжит Олимпийн наадмыг ямар нэг шалтгаанаар зохион явуулаагүй тохиолдолд олимпийн нэг үе нь өмнөх Олимпиадын эхэлсэн өдрөөс хойших дөрвөн жилийн хугацаагаар дуусвар болно.
3. Зуны Олимпийн наадмын дэс дугаарыг 1896 онд Афин хотноо болсон орчин үеийн анхны Олимпийн наадмаас (зуны Олимпийн наадам) эхлэн тоолдог.

### **Арван нэг. Олимпийн наадмын талаар эдлэх эрх**

Олимпийн наадам нь гагцхүү ОУОХ-ны өмч байх бөгөөд түүнтэй холбогдсон бүх эрх, тухайлбал түүнийг зохион байгуулах, ашиглах, мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэн сурталчлах, бичлэг хийх, үзүүлэх, сэргээн давтах, одоо байгаа болон цаашид боловсруулах ямар ч хэлбэр, арга хэрэгслээр дамжуулан мэдээ баримт олж авах, түгээн дэлгэрүүлэх аливаа эрхийг ямар ч хязгаарлалтгүйгээр эдлэх болно. ОУОХ нь Олимпийн наадам болон Олимпийн наадмын уралдаан тэмцээнд хамаатай бүх мэдээллийг авах, ашиглах болзлыг тодорхойлж өгнө.

Олимпийн наадмыг зохион явуулснаас олох бүх орлогыг олимпийн хөдөлгөөн, спортыг хөгжүүлэхэд зориулна.

### **Арван хоёр. Олимпийн билгэдэл\***

1. Олимпийн билгэдэл нь дан ганц өнгөтэй эсвэл хэд хэдэн өнгийн таван цагариг байна.
2. Таван цагариг нь цэнхэр, шар, хар, ногоон, улаан гэсэн өнгийн дарааллаар байна. Цагаригууд зүүнээс баруун гар тийш сүлжилдсэн байна. Цэнхэр, хар, улаан өнгийн цагариг нь дээд талд, харин шар, ногоон өнгөтэй цагариг нь доод хэсэгт байна. Таван цагариг нь доод хэсэгтээ арай богино параллель бүхий зөв трапец хэлбэртэй байрласан байх бөгөөд ОУОХ-ны төв байранд хадгалагдаж буй албан ёсны дүрс зурагтай нийцэж байх ёстой.
3. Олимпийн билгэдэл нь таван тивийн эв нэгдлийг, мөн дэлхийн бүх тамирчдын Олимпийн наадмын үеэрх уулзалтыг билгэдэж байдаг юм.

### **Арван гурав. Олимпийн далбаа\***

Олимпийн далбаа нь ямар ч эмжээргүй цагаан өнгийн байна. Далбааны голд Олимпийн билгэ тэмдэг болох таван өнгийн цагариг байна. Түүний дизайн, хэмжээ нь 1914 онд Парис хотноо болсон Их хурлын үеэр Пьер де Кубертиний гардуулсан далбаатай дүйцэж байх ёстой.

### **Арван дөрөв. Олимпийн уриа**

“Citius, Altius, Fortius” (хурднаас хурдан, өндрөөс өндөр, хүчтэйгээс хүчтэй) гэсэн олимпийн уриа нь олимпийн хөдөлгөөнд хамрагдсан бүх хүмүүст хандсан ОУОХ-ны илгээлт бөгөөд түүгээрээ олимпийн үзэл санааны дагуу эрхмийн дээдэд өгсөн дэвжихийг уриалсан байдаг.

### **Арван тав. Олимпийн онцлох тэмдэг\***

1. Олимпийн онцлох тэмдэг нь олимпийн таван цагаригийг өөр нэгэн ялгах зүйлтэй хослуулсан зохиомжтой байна.
2. Олимпийн онцлох тэмдгийн загварыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлуулсан байх хэрэгтэй.

### **Арван зургаа. Олимпийн дуулал\***

Олимпийн дууллыг Токио хотноо 1958 онд болсон ОУОХ-ны 55 дугаар Чуулганаар баталсан бөгөөд нот (партигур) нь ОУОХ-ны төв байранд хадгалагдаж байна.

### **Арван долоо. Олимпийн билгэдэл, далбаа, уриа, онцлох тэмдэг, дууллыг эдлэх эрх**

Олимпийн билгэдэл, далбаа, уриа, онцлох тэмдэг, дуулалтай\* хамааралтай эрхийг зөвхөн ОУОХ эдэлнэ.

### **Хартийн 12,13, 14, 15, 16,17- т өгөх албан ёсны тайлбар**

1.
  - 1.1 ОУОХ олимпийн билгэдэл, далбаа, уриа, дууллыг үндэсний болон олон улсын хэмжээнд хууль ёсоор хамгаалахаар зохих арга хэмжээ авч болно.
  - 1.2 Тухайн улсын хууль тогтоомжоор эсвэл барааны тэмдгийн бүртгэлийн журмын дагуу ҮОХ нь олимпийн билгэдлийг хамгаалах эрхээр хангагдсан байлаа ч ҮОХ- д зөвхөн ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн өгсөн зааварчилгын дагуу уг эрхийг эдэлнэ.
2. ҮОХ бүр Хартийн 12, 13, 14, 15, 16, 17-р заалт болон тэдгээрийн тайлбарыг өөрийн улс оронд биелүүлэх үүрэг хариуцлагыг ОУОХ-ны өмнө хүлээнэ. Олимпийн билгэдэл, далбаа, уриа, дууллыг Олимпийн Хартийн дээрхи заалт ба

тайлбарт зааснаас өөрөөр ашиглахыг хориглосон арга хэмжээ авна. Түүнчлэн ОУОХ-ны эрх ашгийн үүднээс, “Олимпийн” болон “Олимпиад” гэсэн нэрийг зүй бусаар ашиглахыг хориглож, хамгаалахыг хичээнэ.

3. ҮОХ олимпийн билгэдэл, далбаа, уриа, дууллыг дээр хэлсэнчлэн хамгаалах, мөн энэ тухайд гуравдагч талтай гарч болох аливаа зөрөлдөөнийг зохицуулахын тулд ямар ч үед ОУОХ-нд хандаж туслалцаа авахыг хүсч болно.
4. ҮОХороод олимпийн билгэдэл, далбаа, уриа, дууллыг өөрийн үйл ажиллагааны хүрээнд ашиг хонжоо олохын тулд биш харин ингэж ашигласнаар олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлж түүний эрхэм дээд чанарыг хаагдуулахгүй байхыг эрмэлзэнэ. Олимпийн билгэдлийг ашиглах талаар ОУОХ-ны Гүйцэтгэх зөвлөлөөс зөвшөөрөл авсан байх ёстой.
5. ОУОХ нь үндэсний эрх мэдэл бүхий байгууллагаас гаргах шуудангийн марканд олимпийн билгэдлийг ашиглах асуудлаар тухайн улсын ҮОХ-той хамтран ажиллахад дэмжлэг үзүүлнэ. Иймд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс тодорхойлсон болзлын дагуу Олимпийн билгэдэл ашиглахыг зөвшөөрч болно.
6. ОУОХ Олимпийн нэг эсвэл хэд хэдэн онцлох тэмдгийг бүтээж, өөрийн үзэмжээр ашиглаж болно.
7.
  - 7.1 Олимпийн онцлох тэмдгийг ҮОХ- д эсвэл Олимпийн наадмыг зохион байгуулах хорооноос бий болгож болно.
  - 7.2 Энэ онцлох тэмдэг нь олимпийн билгэдэл эсвэл олимпийн бусад онцлох тэмдэгтэй адилшиж давхардаагүй тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс түүний загварыг баталж өгч болно.
  - 7.3 Олимпийн онцлох тэмдэгт орох олимпийн билгэдэл нь тухайн онцлох тэмдгийн нийт талбайн хэмжээний гуравны нэгээс хэтрэхгүй байх хэрэгтэй. Түүнээс гадна олимпийн билгэдлийг олимпийн онцлох тэмдэгт бүрэн бүтэн байдлаар нь гаргах бөгөөд түүнийг ямар нэгэн маягаар өөрчилж болохгүй.
  - 7.4 Түүнчлэн дээр хэлснээс гадна ҮОХ-ны Олимпийн онцлох тэмдэг нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
    - 7.4.1 Онцлох тэмдэг нь тухайн ҮОХ-ны харъяалагдах орны онцлогийг тод харуулсан хийц загвартай байх.
    - 7.4.2 Онцлох тэмдгийн ялгах элемент нь тухайн ҮОХ-ны харъяалагдах орны зөвхөн нэрээр эсвэл түүний товчилсон нэрээр хязгаарлагдахгүй байх.
    - 7.4.3 Онцлох тэмдгийн ялгах элементэд аль нэгэн Олимпийн наадмыг эсвэл тодорхой он, сар, өдөр буюу үйл явдлыг заах ёсгүй, өөрөөр хэлбэл цаг хугацааны хязгаарлалтгүй байх.

- 7.4.4 Онцлох тэмдгийн ялгах элемент нь өөртөө нийтийн шинжтэй, эсвэл олон улсын түгээмэл шинж чанартай утга санааг илэрхийлсэн уриа, нэр буюу өөр бусад үг хэллэгтэй байх ёсгүй .
- 7.5 Дээрх 7.1, 7.2 болон 7.3 дугаар заалтаас гадна Олимпийн наадмыг Зохион байгуулах хорооны онцлох тэмдэг нь дор дурдсан болзол нөхцөлийг хангасан байна. Үүнд:
- 7.5.1 Онцлох тэмдэг нь тухайн ЗБХ-ноос эрхлэн явуулж буй Олимпийн наадамд хамааралтай гэдгийг тодорхой харуулсан хийц загвартай байна;
- 7.5.2 Онцлох тэмдгийн ялгах элементийг тухайн Олимпийн наадмыг Зохион байгуулах хорооны харъяалагдах орны нэрээр аль эсвэл түүний товчилсон нэрээр хязгаарлах ёсгүй;
- 7.5.3 Онцлох тэмдгийн ялгах элемент нь өөртөө нийтийн шинжтэй эсвэл олон улсын шинж чанартай гэсэн сэтгэгдэл төрүүлэх утга санааг илэрхийлсэн уриа, нэр буюу өөр бусад үг хэллэг байх ёсгүй.
- 7.6 Дээрх заалтууд хүчин төгөлдөр болохоос өмнө ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс баталсан аль ч олимпийн онцлох тэмдэг нь хүчинтэй хэвээрээ байна.
- 7.7 Боломжтой бол олимпийн онцлох тэмдгийг тухайн орны ҮОХ зохих газарт бүртгүүлсэн байх хэрэгтэй (хууль ёсны хамгаалалттай болох). ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр онцлох тэмдгээ батлуулсны дараа ҮОХ зургаан сарын дотор түүнийг бүртгүүлж, энэ тухай ОУОХ-нд нотлох баримт гаргана. Тухайн ҮОХороод нь олимпийн онцлох тэмдгээ хамгаалах талаар бололцоотой бүх арга хэмжээ авахгүй, мөн ийм хамгаалалтын тухай ОУОХ-нд мэдэгдэхгүй байх тохиолдолд ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл түүнийг баталснаа цуцалж болох юм. Үүний адил Олимпийн наадмыг Зохион байгуулах хороод нь ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлтэй зөвлөлдөж шийдвэрлэсний дагуу олимпийн онцлох тэмдгээ өөрийн болон бусад улс оронд дээрх заалтад дурдсан ёсоор хамгаалах үүрэгтэй байна. Үндэсний олимпийн хороод болон Олимпийн наадмыг Зохион байгуулах хорооны хийсэн аливаа хамгаалалт нь ОУОХ-ны эсрэг чиглэсэн байх ёсгүй.
8. Олимпийн билгэдэл, далбаа, уриа, дууллыг элдэв зар сурталчилгаанд, арилжаа болон ашиг олох зорилгоор ашиглах нь зөвхөн ОУОХ-ны эрх мэдлийн асуудал байх болно.
9. Олимпийн онцлох тэмдгийг аливаа зар сурталчилгаа, арилжаа болон ашиг олох зорилгоор ашиглахдаа доорх 10 ба 11-р зүйлд заасан болзлыг биелүүлнэ.
10. Олимпийн онцлох тэмдгээ зар сурталчилгаа, арилжаа болон ашиг олох зорилгоор өөрөө шууд буюу зуучлагч гуравдагч эдгээдээр дамжуулан ашиглах хүсэлтэй байгаа ҮОХ буюу Олимпийн наадмыг Зохион байгуулах хороо нь энэ

дүрмийн тайлбарыг баримталж, мөн түүнийг зуучлагч гуравдагч этгээд нь биелүүлсэн байх талаар чармайж ажиллах хэрэгтэй.

11. Бүх гэрээ хэлэлцээрүүд, түүний дотор Олимпийн наадмыг Зохион байгуулах хорооноос хийх гэрээ хэлэлцээрт тухайн ҮОХ гарын үсэг зурж батлах бөгөөд ингэхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

11.1 Аль нэг ҮОХ-ны олимпийн онцлох тэмдгийг ашиглах явдал зөвхөн тухайн ҮОХ-ны харъяалагдах улсын нутаг дэвсгэрт хууль ёсны байна. Ийм онцлох тэмдэг, олимпийн холбогдол бүхий бусад билгэдэл, нэр зэргийг өөр ҮОХ-ны улс оронд тухайн ҮОХ-ны албан ёсны зөвшөөрлийг урьдчилан авалгүйгээр аливаа зар сурталчилгаа, арилжаа болон ашиг олох зорилгоор ашиглаж болохгүй;

11.2 Үүний адил Олимпийн наадмыг Зохион байгуулах хорооны онцлох тэмдэг, ЗБХ-ны олимпийн холбогдол бүхий бусад билгэдэл, өөр тэмдэг нэр зэргийг тухайн ҮОХ-ны албан ёсны зөвшөөрлийг урьдчилан авалгүйгээр аливаа зар сурталчилгаа, арилжаа болон ашиг олох зорилгоор хэрэглэж болохгүй;

11.3 Ямар ч тохиолдолд ЗБХ-ноос байгуулсан аливаа гэрээний хүчин төгөлдөр байх хугацаа нь тухайн Олимпийн наадмын жилийн арванхоёрдугаар сарын 31-нд дуусна;

11.4 Олимпийн онцлох тэмдгийг ашиглах явдал нь олимпийн хөдөлгөөнд тус нэмэр болох зорилготой бөгөөд нэр хүндийг нь хөндөх ёсгүй; олимпийн онцлох тэмдэг болон бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний хоорондох аливаа хамаарал нь Олимпийн Хартийн үндсэн зарчимд тодорхойлсон ОУОХ-ны үүрэгтэй зөрчилдөж байвал хориглоно.

11.5 ОУОХ-ноос тавьсан шаардлагын дагуу аль ч ҮОХ болон ЗБХ өөрийн байгуулсан ямар нэг гэрээнийхээ хувийг танилцуулж байх ёстой.

12. ОУОХ-ны олимпийн билгэдэл болон олимпийн онцлох тэмдгүүдийг ОУОХ буюу түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч аль ч ҮОХ-ны харъяалагдах улс оронд дараах болзлоор ашиглаж болно. Үүнд:

12.1 Ивээн тэтгэлэг, бараа нийлүүлэлт, маркетингийн үйл ажиллагааны бүх хэлэлцээрийг хийхдээ Хартийн 12-р зүйлийн 2-т зааснаас гадна ингэж ашиглах явдал нь тухайн ҮОХ-ны эрх ашигт ноцтой хохирол учруулахгүй байх зарчмыг баримтлана. Энэ талаар ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл тухайн ҮОХ-той зөвлөлдөж шийдвэр гаргах, тийнхүү олимпийн билгэдэл, онцлох тэмдгийг ашигласнаас орох цэвэр орлогын зохих хувийг ҮОХ авах ёстой.

12.2 Лицензийн бүх хэлэлцээр хийхдээ тийнхүү билгэдэл, тэмдэг ашигласнаас орох орлогоос бүх татвар, хураамжийг суутгаж авсаны дараа цэвэр ашгийн тал хувийг ҮОХ-нд өгөх болзолтой байна. Энэ тухай ҮОХ урьдчилан мэдсэн байх ёстой.

Олимпийн наадмын сурталчилгаа хийхдээ олимпийн билгэдэл, онцлох тэмдгийг ашиглах эрхийг Олимпийн наадмаас нэвтрүүлэг хийж буй телевизийн компаниудад ОУОХ өөрийн үзэмжээр олгож болно. Энэхүү тайлбарын 12.1, 12.2 гэсэн заалтууд энд хамаарахгүй.

### **Арван найм. Олимпийн гал, олимпийн бамбар**

1. Олимпийн гал гэдэг бол Олимпийн өлгий нутагт ОУОХ-ны ивээлийн дор асаасан гал юм.
2. Олимпийн бамбар гэдэг бол Олимпийн гал асааж явах бамбар буюу түүнтэй төстэй загвар юм.
3. ОУОХ олимпийн гал, олимпийн бамбар ашиглахтай холбогдсон бүхий л эрхийг эдлэнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ**

### **ОЛОН УЛСЫН ОЛИМПИЙН ХОРОО (ОУОХ)**

#### **Арван ес. Хууль ёсны эрх хэмжээ**

1. ОУОХ бол тодорхой хугацаагүйгээр байгуулагдсан олон улсын төрийн бус, ашгийн бус байгууллага юм. Тус байгууллага нь Швейцарын Холбооны Зөвлөлөөр хүлээн зөвшөөрөгдсөн холбооны хэлбэртэй хуулийн этгээд болно.
2. ОУОХ-ны төв нь Швейцарын Лозанн хотод байнга байрладаг
3. ОУОХ-ны үүрэг зорилт нь олимпийн хөдөлгөөнийг Олимпийн Хартийн дагуу удирдан зохион байгуулах явдал мөн.
4. Олимпийн Хартийн заалтыг үндэслэн гаргасан ОУОХ-ны шийдвэр нь эцсийнх байх болно. Түүнийг биелүүлэх буюу тайлбарлахтай холбогдсон аливаа маргаантай асуудлыг гагцхүү ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл таслан шийдвэрлэх бөгөөд зарим тохиолдолд Спортын арбитрын шүүхээр (САШ) шийдвэрлэнэ.

#### **Хорь. Гишүүд**

1. **ОУОХ-ны бүрэлдэхүүн – ОУОХ-нд шинэ гишүүн элсүүлэх, сонгох, батлах, эрх хэмжээг нь тодорхойлох.**
  - 1.1 ОУОХ-ны гишүүд хувь хүмүүс байна. ОУОХ-ны гишүүд нь уралдаан тэмцээнд оролцдог тамирчид, Олон улсын спортын холбоодын, мөн Хартийн 4-ийн 5-д заасан ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн бусад байгууллагууд, ҮОХ-дын ерөнхийлөгчид эсвэл тэдгээрийн дээд албан тушаалын хүмүүс байж болно. ОУОХ-ны нийт гишүүдийн тоо нь 115-аас хэтрэхгүй байх ёстой

бөгөөд энэ тухайд эл дүрмийн албан ёсны тайлбарын 2.8-д тодорхойлсон сэлгэлтийн тухай заалтыг баримтална.

1.2 ОУОХ энэ дүрмийн тайлбарын зохих заалтын дагуу тэнцэх хүмүүсээс өөрийн гишүүдийг элсүүлэн сонгоно.

1.3 ОУОХ шинэ гишүүдийг батлах ёслол дээр тэд үүргээ бүрэн биелүүлэхээ илэрхийлж дараах тангараг өргөнө. Үүнд:

“Олон улсын олимпийн хорооны гишүүн болж энэ байгууллагыг төлөөлөх нэр төрийг хүлээж буй энэ мөчид өөрийн үүргээ бүрэн ухамсарлан хамаг хүч чадал, боломжоо олимпийн хөдөлгөөнд зориулан зүтгэж, Олимпийн Хартийн заалт, мөн ОУОХ-ны шийдвэрийг хүндэтгэн чанд биелүүлж, ёс зүйн журмыг баримтлан, аливаа улс төр, худалдаа арилжааны нөлөө, түүнчлэн арьс өнгө, шашин шүтлэгийн шинжтэй элдэв үзэл бодлоос ангид байж, ялгаварлан гадуурхах явдлын бүх хэлбэрийн эсрэг тэмцэж, ямар ч тохиолдолд ОУОХ болон олимпийн хөдөлгөөний эрх ашгийг ямагт хамгаалж явахаа батлан тангараглаж байна.”

1.4 ОУОХ-ны гишүүд нь тус байгууллагыг төлөөлнө.

1.5 ОУОХ-ны гишүүд засгийн газар эсвэл аль нэгэн байгууллага, хуулийн этгээд, хувь хүнээс өөрийн үйл ажиллагаа болон санал өгөх эрх чөлөөнд саад тотгор болох үүрэг даалгавар авч болохгүй.

1.6 ОУОХ-ны гишүүд ОУОХ-ны өр төлбөр болон үүрэг амлалтын тухайд хувийн хариуцлага хүлээхгүй.

## **2. Гүйцэтгэх үүрэг**

ОУОХ-ны гишүүн бүр дараах үүрэгтэй байна. Үүнд:

2.1 ОУОХ-ны Чуулгануудад оролцох;

2.2 ОУОХ-ны комиссуудын ажилд томилсоны дагуу оролцох;

2.3 Олимпийн хөдөлгөөнийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

2.4 ОУОХ-ны хөтөлбөрүүдийг, үүний дотор “Олимпийн эв санааны нэгдэл” хөтөлбөрийг тухайн газарт хэрэгжүүлэх явцад хяналт тавих;

2.5 Олимпийн хөдөлгөөний хөгжлийн явц, түүний хэрэгцээ шаардлагын талаар жилд нэгээс доошгүй удаа ОУОХ-ны Ерөнхийлөгчид мэдээлэх;

2.6 Олимпийн Хартийг биелүүлэхэд саад болох буюу Олимпийн хөдөлгөөнд муугаар нөлөөлөх аливаа үйл явдлын тухай ОУОХ-ны Ерөнхийлөгчид нэн даруй мэдэгдэх;

2.7 Хартийн 25-р заалтын дагуу Ёс зүйн журмыг ямагт дагаж мөрдөх;

2.8 Ерөнхийлөгчийн өгсөн бусад үүрэг даалгаварыг биелүүлж, мөн шаардлагатай үед өөр орон болон өөрийн орны нутаг дэвсгэрт буюу байгууллагад ОУОХ-г төлөөлөн ажиллах.

### **3. ОУОХ-ны гишүүн байх эрхээ алдах нь**

3.1 ОУОХ-ны гишүүн хэн боловч ямар ч үед өөрөө огцрох тухай өргөдлөө ОУОХ-ны Ерөнхийлөгчид өргөн барьж ОУОХ дахь гишүүнчлэлээ зогсоож болно. Харин тэгж огцруулахын өмнө ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл огцрох гэж буй гишүүний үгийг сонсож болно.

3.2 Энэ дүрмийн тайлбарын 2.6 болон 2.7-д заасны дагуу улиран сонгогдоогүй ОУОХ-ны аль ч гишүүн шууд л гишүүн байх эрхээ алдана.

3.3 ОУОХ-ны гишүүн 70 нас хүрсэн тухайн жилийн эцэс гэхэд гишүүнээс огцрох ёстой. Ингэхдээ энэхүү дүрмийн тайлбарын 2.8-д тодорхойлсон сэлгэлтийн журмыг баримтлана.

3.4 Гишүүнээс огцрох нь

3.4.1 Хартийн тайлбарын 2.2.1-д заасны дагуу уралдаан тэмцээнд оролцдог тамирчны хувьд нэр дэвшигдэн сонгогдсон ОУОХ-ны гишүүн нь ОУОХ-ны Тамирчдын комиссын гишүүн байхаа больсон нөхцөлд ОУОХ-ны гишүүнээс тэр даруй огцрох болно.

3.4.2 Хартийн тайлбарын 2.2.2 болон 2.2.3-р заалтад тодорхойлогдсон аль нэгэн байгууллагаас ОУОХ-ны гишүүнд нэр дэвшигдэн сонгогдсон хүн энэ ажил үүргээ гүйцэтгэхгүй болсон нөхцөлд ОУОХ-ны гишүүнээс тэр даруй огцрох болно.

3.5 Хартийн тайлбарын 2.2.4-д заасны дагуу ОУОХ-ны гишүүнд нэр дэвшигдэн сонгогдсон аливаа гишүүн энэ дүрмийн 5-р зүйлд тодорхойлсон гишүүдийн нэрсийн жагсаалтад дурьдсан улс оронд оршин суухаа больсон эсвэл тэнд өөрийн сонирхолгүй болсон бол гишүүнээс огцорсон гэж үзэн ОУОХ-ны Чуулганы шийдвэрээр үүнийг батлана.

3.6 Онцгой нөхцөл байдлаас шалтгаалаагүй бол хоёр жилийн хугацаанд ОУОХ-ны Чуулганд, мөн тус байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцохгүй байх тохиолдолд ОУОХ-ны гишүүнээс огцорсон гэж үзэн ийм гишүүнийг өөрөөр нь өргөдөл гаргуулахгүйгээр шууд хасна. Ийм тохиолдолд гишүүний эрхээ алдсан болохыг ОУОХ-ны Чуулганы шийдвэрээр батална.

3.7 ОУОХ-ны гишүүн, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүн эсвэл өргөмжлөлт гишүүн нь өргөсөн тангарагаасаа няцвал ОУОХ-ны Чуулганы шийдвэрээр эсвэл ОУОХ-ны эрх ашгийг үл тоомсорлосон буюу зориуд түүнийг хөсөрдүүлсэн, ОУОХ-ны нэр хүндэд нийцэхгүй үйлдэл хийсэн гэж Чуулганаас үзвэл тэдгээрийг ОУОХ-ны шийдвэрээр гишүүнээс хасч болно.

3.8 ОУОХ-ны гишүүн, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүн өргөмжлөлт гишүүнийг эгнээнээсээ хасах асуудлыг Гүйцэтгэх Зөвлөлийн

саналыг үндэслэж Чуулганд оролцогч гишүүдийн гуравны хоёрын олонхийн саналаар шийдвэрлэнэ. Тухайн гишүүнд ОУОХ-ны Чуулганд өөрийн биеэр байлцаж учир шалтгаанаа хэлэх боломж олгоно.

Гишүүнээс хасах ОУОХ-ны Чуулганы шийдвэр гартал ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл тухайн хүний гишүүнчлэлтэй холбогдсон эрх мэдэл болон ажил үүргийн зарим хэсгийг эсвэл бүгдийг нь түр хасч болно.

ОУОХ-ны гишүүн, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүн эсвэл өргөмжлөлт гишүүнээс хасагдсан хүн ҮОХ-ны гишүүн, мөн ҮОХ-дын холбоо эсвэл Олимпийн наадмыг ЗБХ-ны гишүүн байж болохгүй. Ямар ч нөхцөлд эдгээр хүмүүс дахин ОУОХ-ны гишүүн, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүн эсвэл өргөмжлөлт гишүүн болох эрх байхгүй.

#### **4. Насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч - хүндэт гишүүд – өргөмжлөлт гишүүд**

4.1 ОУОХ-ны Ерөнхийлөгчийн алба хашихдаа онцгой үйл бүтээсэн хүнийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн саналыг үндэслэн насан туршийн Хүндэт Ерөнхийлөгчөөр сонгож болох юм. Насан туршийн Хүндэт Ерөнхийлөгчийг Олимпийн наадам, Олимпийн их хурал, ОУОХ-ны Чуулган, ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн хуралд урьж оролцуулах бөгөөд түүний суух суудлыг ОУОХ-ны Ерөнхийлөгчийн дэргэд байлгана. Насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч нь зөвлөх эрхтэй байх бөгөөд харин санал өгөх эрхгүй.

4.2 ОУОХороонд 10-аас доошгүй жил алба хааж онцгой гавъяа байгуулсан гишүүнийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн саналаар ОУОХ-ны хүндэт гишүүнээр сонгож болно. Хүндэт гишүүдийг Олимпийн наадам, Олимпийн их хурал, ОУОХ-ны Чуулганд урилгаар оролцуулж тусгай бэлтгэсэн суудалд суулгана. Тэд ОУОХ-ны Ерөнхийлөгчийн хүсэлтээр зөвлөлгөө өгч болох ба харин санал хураалтанд оролцох эрхгүй байна.

4.3 ОУОХороонд онцгой хувь нэмэр оруулсан зүтгэлтнийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн саналаар өргөмжлөлт гишүүнээр сонгож болно. Ийм өргөмжлөлт гишүүд нь санал хураалтанд оролцох эрхгүй байна. Тэд Олимпийн наадам болон Олимпийн их хуралд урилгаар оролцох бөгөөд тэдэнд суудал бэлтгэсэн байна. ОУОХ-ны Ерөнхийлөгч ОУОХ-ны хурал зөвлөлгөөн, бусад арга хэмжээнд тэднийг оролцохыг урьж болох юм.

#### **5. Гишүүдийн нэрсийн жагсаалт**

ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл ОУОХ-ны бүх гишүүд, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүд, өргөмжлөлт гишүүдийн нэрсийн жагсаалтыг байнга шинэчлэж байна. Хартийн тайлбарын 2.2.1-д заасан ёсоор уралдаан тэмцээнд оролцдог тамирчин ОУОХ-ны гишүүнд нэр дэвшигдэн сонгогдсон эсвэл Хартийн тайлбарын 2.2.2 ба 2.2.3 -д заасан аль нэгэн байгууллагад ажил үүрэг гүйцэтгэж тэндээс нэр дэвшигдэн сонгогдсон байвал үүнийг уг жагсаалтад зааж өгнө.

## Хартийн 20-т өгөх албан ёсны тайлбар

### 1. Сонгуульд оролцох болзол

1.1 Аливаа улсын 18 ба түүнээс дээш насны иргэн хүн дараах болзлыг хангасан байвал ОУОХ-ны гишүүнээр сонгогдож болно. Үүнд: дор өгүүлсэн 2.1-р заалтын дагуу нэр дэвшигдсэн байх; доорх 2.1-р заалтын болзолд тохирсон байх; нэр дэвшигчийг Магадлан тодорхойлох комиссоос судалсан байх; нэр дэвшигчийг сонгох асуудлыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс Чуулганаар хэлэлцэх асуудалд санал оруулсан байх гэх зэрэг болзолтой байна.

1.2 ОУОХ-ны бүх гишүүнд зохих дүрмийн тайлбарт заасны дагуу 8 жилээр сонгогдоно. Хартийн 20-ийн 3.3, 3.4, 3.5 болон 3.6-д заасны дагуу тэд дахин сонгогдох эрхтэй байна.

### 2. ОУОХ-ны гишүүдийг сонгох журам

2.1 ОУОХ-ны гишүүнээр сонгохоор нэр дэвшүүлэх нь

Дараах байгууллага, хүмүүс ОУОХ-ны гишүүнээр нэг буюу хэд хэдэн нэр дэвшүүлэх эрхтэй байна. Үүнд:

- *ОУОХ-ны гишүүд*: ОУОХ-ны гишүүн бүр ОУОХ-ны гишүүнээр сонгох нэг буюу хэд хэдэн хүний нэр дэвшүүлэх эрхтэй.
- *ОУОХ-ны Тамирчдын комисс*: ОУОХ-ны Тамирчдын комисс нь ОУОХ-ны гишүүнээр сонгох нэг буюу хэд хэдэн нэр дэвшүүлэх эрхтэй байна.
- *Олимпийн төрлүүдийн Олон улсын спортын холбоод*: Зуны Олимпийн олон улсын спортын холбоодын нэгдэл (ASOIF), Өвлийн Олимпийн олон улсын спортын холбоодын нэгдэл (AIOWF) болон тэдгээрийн гишүүн Олон улсын спортын холбоод нь ОУОХ-ны гишүүнээр сонгохоор нэг буюу хэд хэдэн хүний нэр дэвшүүлэх эрхтэй.
- *Үндэсний олимпийн хороод*: Үндэсний олимпийн хороодын холбоо (ANOC), Африкийн Үндэсний олимпийн хороодын холбоо (ANOCA), Европын олимпийн хороод (EOC), Азийн олимпийн зөвлөл (OCA), Пан-Америкийн спортын байгууллага (PASO), Далайн орнуудын Үндэсний олимпийн хороод (ONOC) нь ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн ҮОХороодтой хамтран ОУОХ-ны гишүүнээр сонгох нэг буюу хэд хэдэн хүний нэр дэвшүүлэх эрхтэй байна.

Сонгуульд оролцуулах нэр дэвшигчийг ОУОХ-ны Ерөнхийлөгчид бичгээр танилцуулна. Түүнээс гадна тэд бүх тохиолдолд доорх 2.2-р заалтын болзлыг хангасан байх ёстой.

2.2 Нэр дэвшигчид дараах болзлыг биелүүлнэ. Үүнд:

Дээрх 2-ын 1-р заалтад дурдсан бүх хүмүүс буюу байгууллага нь доорх 2.2.1, 2.2.2 буюу 2.2.3-д заасны дагуу ОУОХ-ны гишүүнээр сонгох нэг буюу хэд хэдэн

хүний нэр дэвшүүлэхдээ нэр дэвшигч тус бүрийг доорх 2.2.1-д дурдсан уралдаан тэмцээнд оролцдог тамирчин болохыг эсвэл 2.2.2 буюу 2.2.3-д заасан аль нэгэн байгууллагад ажил үүрэг гүйцэтгэж байгааг нь маш сайн тодорхойлж өгнө.

2.2.1 Хэрэв нэр дэвшигч Хартийн 20-р заалтын 1.1-д заасан уралдаан тэмцээнд оролцдог тамирчин байвал тэрээр ОУОХ-ны Тамирчдын комиссын гишүүн байх ёстой. Уг тамирчин нь түүний хамгийн сүүлд оролцсон Олимпийн наадмын удаах зуны буюу өвлийн Олимпийн наадам эхлэхээс өмнө ОУОХ-ны Тамирчдын комисст гишүүнээр сонгогдсон байх хэрэгтэй.

Нэг буюу хэд хэдэн хүний нэр дэвшүүлэхдээ ОУОХ-ны Тамирчдын комисс нь өвөл, зуны спортын төрлүүдийг төлөөлсөн тамирчдаас нэр дэвшигчдийн тоог тэнцүү байлгана. Ийм журмаар нэр дэвшигдэн ОУОХ-нд нэг удаа сонгогдох нийт гишүүдийн тоо нь 15-аас хэтрэхгүй байх ёстой.

2.2.2 Хэрэв нэр дэвшигч Олон улсын спортын холбоо, олон улсын спортын холбоодын нэгдэлд Хартийн 4-ийн 5-р заалтад зааснаар ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн байгууллагад ажил үүрэг гүйцэтгэдэг байвал тэрээр ОУСХ, АSOIF, АIOWF буюу хүлээн зөвшөөрүүлсэн өөр бусад байгууллагын ерөнхийлөгч эсвэл эдгээр байгууллагын аль нэгэнд удирдах албан тушаалтан байх ба ийм журмаар нэр дэвшигдэн ОУОХ-нд нэг удаа сонгогдох нийт гишүүдийн тоо нь 15-аас хэтрэхгүй байх ёстой.

2.2.3 Хэрэв нэр дэвшигч YOX, YOX-дын олон улсын буюу тивийн холбоодод ажил үүрэг гүйцэтгэдэг байвал тэрээр YOX, ANOC, ANOCA, EOC, OCA, PASO, ONOC-ийн ерөнхийлөгч эсвэл эдгээр байгууллагын аль нэгэнд удирдах албан тушаалтан байх ёстой. Ийм нэр дэвшигчдийн тухайд бол нэг орноос нэг л гишүүн сонгогдож болно. Ингэж нэр дэвшигдэн нэг удаагийн сонгуулиар ОУОХ-нд сонгогдох нийт гишүүдийн тоо нь 15-аас хэтрэхгүй байх ёстой.

2.2.4 Өөр бусад нэр дэвшигчдийн тухайд бол тэдгээр нь байнга оршин суудаг эсвэл тэдгээрийн сонирхолын гол төв болох улсын иргэн байх, мөн тэр улсад ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн YOX байх ёстой. Ийм нэр дэвшигчдээс нэг орныг төлөөлөн нэг л гишүүн сонгогдож болно. Ингэж нэг удаагийн сонгуулиар ОУОХ-нд сонгогдсон нийт гишүүдийн тоо 70-аас хэтрэхгүй байна.

### 2.3 Магадлан тодорхойлох комисс

2.3.1 Магадлан тодорхойлох комисс долоон гишүүнээс бүрдэх бөгөөд түүний гурван гишүүнийг ОУОХ-ны Ёс зүйн комиссоос, нөгөө гурван гишүүнийг ОУОХ-ны Чуулганаас, нэг гишүүнийг ОУОХ-ны Тамирчдын комиссоос тус тус сонгоно. Тус комиссын гишүүдийг дөрвөн жилээр сонгох ба тэд дахин сонгогдож болно.

2.3.2 Магадлан тодорхойлох комиссын зорилго нь нэр дэвшигч тус бүрийг доорх 2.4.2-д заасан ёсоор судалж энэ тухай ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд бичгээр тайлагнана.

2.3.3 Магадлан тодорхойлох комисс өөрийн дотоод бүтэцтэй байна; тус комисс нь дарга, нарийн бичгийн даргыг томилох ба нарийн бичгийн даргаар комиссын гишүүн биш гадны хүнийг сонгож болно.

2.4 Магадлан тодорхойлох комисс нэр дэвшигчдийг судлах нь:

2.4.1 ОУОХ-ны Ерөнхийлөгч нэр дэвшигчийн танилцуулгыг авмагц түүнийг Магадлан тодорхойлох комиссын даргад шилжүүлэх ба тэрээр тухайн нэр дэвшигчийн танилцуулгын дугтуйг задлах даалгавар өгнө. ОУОХ-ны дараачийн Чуулган нээхээс гурван сарын өмнө энэхүү танилцуулга бүхий дугтуйг задалж судалсан байх ёстой. Тэгвэл Гүйцэтгэх Зөвлөл нь цаг хугацаа алдалгүйгээр Чуулганд санал оруулах боломжтой байх болно.

2.4.2 ОУОХ-ны Ерөнхийлөгчөөс нэр дэвшигчийн танилцуулгыг хүлээн авмагц Магадлан тодорхойлох комиссын дарга энэ тухай комиссын гишүүдэд нэн даруй зохих ёсоор мэдэгдэж зөвлөлдөнө. Тус комисс нэр дэвшигчийн тухай холбогдох бүх мэдээллийг, ялангуяа түүний мэргэжлийн болон эд материалын байдал, ажил төрөл, спортын үйл ажиллагааны тухай мэдээллийг цуглуулна; ийм мэдээлэл авах зорилгоор мөнөөх комисс нэр дэвшигчийг мэдэх хүмүүсээс санал тодорхойлолт гаргаж өгөхийг хүсэх, мөн нэр дэвшигчээс ярилцлага авч болно.

2.4.3 Тус комисс бүх нэр дэвшигчийн гарал үүсэл, мөн шаардлагатай гэвэл нэр дэвшигч нь уралдаан тэмцээнд оролцдог тамирчин мөн эсэх, нэр дэвшигчийн ажил үүргийг үнэн зөв тодорхойлсон эсэхийг шалгаж болно.

2.4.4 Бүх шаардлагатай мэдээ баримт цуглуулсаны дараа Магадлан тодорхойлох комисс нэр дэвшигч нь ОУОХ-ны гишүүнээр сонгогдох шалгуурт тэнцэх эсэх тухай дүгнэлт гаргаж Гүйцэтгэх Зөвлөлд бичгээр танилцуулна. Тухайн нэр дэвшигч нь дээрх 2.2.1-р заалтад заасан уралдаан тэмцээнд оролцдог тамирчин эсвэл 2.2.2 болон 2.2.3-р заалтад дурдсан аль нэгэн байгууллагад ажил үүрэг гүйцэтгэдэг бол үүнийг уг комиссын тайланд тэмдэглэнэ.

2.5 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр хэлэлцэх журам

2.5.1 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл нэр дэвшигчийг хэлэлцэх асуудлыг Чуулганд оруулах эрхтэй байна.

2.5.2 Гүйцэтгэх Зөвлөл Магадлан тодорхойлох комиссын тайланг хүлээн авч судалсны дараа нэр дэвшигчийг ОУОХ-ны гишүүнээр сонгох санал чуулганд оруулах асуудлаа өөрийн хурлаар шийдвэрлэх ба шаардлагатай бол нэр дэвшигчийн (нэр дэвшигчдийн) үгийг сонсож болно. Гүйцэтгэх Зөвлөл нь нэр дэвшигчийг сонгох саналаа Чуулган эхлэхээс 30 хоногийн өмнө бичгээр өгөх ба түүнд Магадлан тодорхойлох комиссын тайланг хавсаргана.

Гүйцэтгэх Зөвлөл нэр дэвшигч тус бүрийн гарал үүсэл, шаардлагатай гэж үзвэл тухайн нэр дэвшигч нь дээрх 2.2.1-р заалтад тодорхойлсон уралдаан тэмцээнд оролцдог тамирчин мөн үү гэдгийг, эсвэл дээр дурьдсан 2.2.2 ба 2.2.3-д дурдсан аль нэгэн байгууллагад ажил үүрэг гүйцэтгэж буй эсэхийг тэмдэглэнэ. Гүйцэтгэх Зөвлөлөөс нэг гишүүний орон тоонд хэд хэдэн нэр дэвшигчийг санал болгож болно.

2.5.3 Дээрх 2.2.1-д тодорхойлсон уралдаан тэмцээнд оролцдог тамирчдын хувьд нэр дэвшигчдийг хэлэлцэх явцыг түргэсгэж болно. Ийм тохиолдолд дээрх 2.4.1, 2.5.2-д заасан эцсийн хугацааг ОУОХ-ны Тамирчдын комисст шинээр сонгогдсон тамирчдыг ОУОХ-ны гишүүнээр сонгогдоход шаардагдах хэмжээгээр өөрчилж болно.

## 2.6 ОУОХ-ны Чуулганаар хэлэлцэх журам

2.6.1 Зөвхөн ОУОХ-ны Чуулган нь ОУОХ-ны аль ч гишүүнийг сонгох эрх мэдэлтэй байна.

2.6.2 Гүйцэтгэх Зөвлөлөөс ОУОХ-ны гишүүнээр сонгохоор Чуулганд оруулсан бүх нэр дэвшигчдийг нууц санал хураалтаар олонхийн саналаар баталж шийдвэрлэнэ.

2.6.3 Магадлан тодорхойлох комиссын дарга нь тус комиссын саналыг Чуулганд уламжилж болно.

## 2.7 Дахин сонгох журам

Найман жилийн хугацаатай дахин сонгогдох эрхтэй ОУОХ-ны гишүүдийг дахин сонгох журмын 2.4, 2.5, 2.6-д дурдсан заалтын дагуу хэрэгжүүлнэ. Түүнийг түргэсгэх буюу хялбаршуулж болно.

## 2.8 Сэлгээ хийх журам

ОУОХ-ны 110 дугаар Чуулган нээх өдрөөс (1999 оны 12-р сарын 11) өмнө сонгогдсон ОУОХ-ны гишүүдийн тогтсон эрх нь дараах байдлаар хадгалагдсан байна. Үүнд:

2.8.1 ОУОХ-ны 110 дугаар Чуулган нээх өдрөөс (1999 оны 12-р сарын 11) өмнө сонгогдсон ОУОХ-ны гишүүн нь 1966 оноос өмнө сонгогдоогүй бол 80 нас хүрэх хуанлийн жилийн эцсээр огцрох ёстой. Хэрэв ОУОХ-ны гишүүн, Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгч, Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүн байгаад ийм насанд хүрсэн байвал ОУОХ-ны дараах Чуулганы төгсгөлд гишүүнээс огцорно.

2.8.2 Түүнээс гадна ОУОХ-ны 110 дугаар Чуулган нээх өдрөөс (1999 оны 12-р сарын 11) өмнө сонгогдсон, дээрх 2.8.1-д заасан насны хязгаарт хүрээгүй ОУОХ-ны гишүүдийн гуравны нэгийг нь 2007 онд, мөн гуравны нэгийг нь 2008 онд, үлдэх гуравны нэгийг нь 2009 онд эл Хартийн тайлбарын 2.6-д заасан нөхцлийн дагуу ОУОХ-ны Чуулганаар дахин сонгоно. Гишүүдийн ийнхүү сонгогдох хуваарийг ОУОХ-ны 111 дүгээр Чуулганаар шодох журмаар шийднэ.

2.8.3 2000 оны зуны Олимпийн наадмыг тохиолдуулан найман тамирчныг ОУОХ-ны Тамирчдын комисс сонгоно. Хамгийн олон санал авсан дөрвөн гишүүнийг найман жилээр, удаах олон санал авсан дөрвөн гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар тус тус сонгоно.

2.8.4 2002 оны өвлийн Олимпийн наадмыг тохиолдуулан дөрвөн тамирчныг ОУОХ-ны Тамирчдын комисст сонгох болно.

Хамгийн олон санал авсан хоёр гишүүнийг найман жилээр, удаах олон санал авсан хоёр гишүүнийг дөрвөн жилийн хугацаагаар тус тус сонгоно.

2.8.5 Хэрэв ОУОХ-ны Тамирчдын комиссын гишүүд нь ОУОХ-ны 110 дугаар Чуулганаар ОУОХ-ны гишүүнээр сонгогдсон байвал тэдний бүрэн эрхийн хугацаа ОУОХ-ны Тамирчдын комисст гишүүнээр сонгогдсоноос хойш дөрвөн жилийн дараа зуны болон өвлийн Олимпийн наадмын албан ёсны хаалтын дараа дуусна.

2.8.6 Дээрх 2.1, 2.3, 2.4, 2.5.2 болон 2.6.2-д дурдсан заалт нь зөвхөн 2000 оны 1 дүгээр сарын 1-ний байдлаар уралдаан тэмцээнд оролцдог тамирчдын сонгуульд хамааралтай байна.

2.8.7 2007 оны 12 -р сарын 31-ний өдрөөс өмнө ОУОХ-ны нийт гишүүдийн тоо 130-д хүрч болно.

### **Хорин нэг. ОУОХ-ны зохион байгуулалт**

ОУОХ дараах байгууллагуудтай байна. Үүнд:

1. Чуулган,
2. Гүйцэтгэх Зөвлөл,
3. Ерөнхийлөгч,
4. Хэрэв ОУОХ-ны аль нэгэн байгууллагын эрх мэдлийг тодорхойлоход эргэлзэх явдал гарвал “ОУОХ” гэсэн нэр томъёог өөр ямар нэгэн нэмэлт тодотголгүйгээр хэрэглэсэн тохиолдолд түүнийг “Чуулган” гэж ойлгож болно. Гэхдээ зарим тохиолдолд эрх мэдлийг нь Гүйцэтгэх Зөвлөлд шилжүүлэн өгсөн байж болох юм.

### **Хорин хоёр. Чуулган**

1. ОУОХ-ны нийт гишүүдийн хурал болох Чуулганыг жилд нэгээс доошгүй удаа хийнэ. Онц Чуулганыг Ерөнхийлөгчийн санаачилгаар гишүүдийн гуравны нэгийн бичгээр өгсөн шаардлагын дагуу хуралдуулна.
2. Чуулган хийх газрыг ОУОХ-ноос, онц Чуулган хуралдуулах газрыг Ерөнхийлөгч тогтооно. Ерөнхийлөгч Чуулган болон онц Чуулганыг хуралдуулах тухай мэдэгдлийг хэлэлцэх асуудлын хамт Чуулган болохоос нэг сарын өмнө илгээнэ.

3. Чуулган зохион байгуулах, түүнтэй холбогдсон санхүүгийн бүх асуудлыг “Хурал зохион байгуулах удирдамж” болон ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс гаргасан бусад баримт бичгийн дагуу зохицуулна.
4. Чуулган бол ОУОХ-ны эрх барих дээд байгууллага мөн. Түүгээр Олимпийн Хартийг батлах, өөрчлөх, тайлбар хийх болно. Чуулганы шийдвэр нь эцсийнх байх болно. Гүйцэтгэх Зөвлөлийн өгсөн саналын дагуу ОУОХ-ны гишүүдийг сонгоно.
5. Чуулган эрх мэдлээ Гүйцэтгэх Зөвлөлд шилжүүлж болно.

### **Хорин гурав. Гүйцэтгэх Зөвлөл**

#### **1. Бүрэлдэхүүн**

Гүйцэтгэх Зөвлөл нь Ерөнхийлөгч, дөрвөн Дэд ерөнхийлөгч болон бусад арван гишүүнээс бүрдэнэ. Эдгээр гишүүд нь Чуулганы бүрэлдэхүүнээс сонгогдоно. Дээрх зарчмыг сонгууль бүрд баримталж байхыг Чуулганаас хянаж байна.

#### **2. Сонгууль**

Гүйцэтгэх Зөвлөлийн бүх гишүүдийг Чуулганаас нууц санал хураалтаар олонхийн саналаар сонгоно.

#### **3. Бүрэн эрхийн хугацаа, түүнийг шинэчлэх нь**

- 3.1 Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа, мөн улиран сонгогдох талаар Хартийн 24-т өгүүлсэн байгаа.
- 3.2 Дэд ерөнхийлөгч болон Гүйцэтгэх Зөвлөлийн бусад арван гишүүний бүрэн эрхийн хугацаа нь дөрвөн жил байна. Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүнд сонгогдсон албан тушаалаас хамаарахгүйгээр Гүйцэтгэх Зөвлөлд дээд тал нь хоёр удаа сонгогдож болно. Аль нэгэн гишүүнийг орлон ажилласан хугацааг доорх 4-р зүйлд заасан ёсоор үүнд тооцохгүй.
- 3.3 Дээрх 3.2-д тодорхойлсон бүрэн эрхийн улиран сонгогдсон хугацааг дуусгасан гишүүн хоёр жилийн дараа Гүйцэтгэх Зөвлөлийн гишүүнээр сонгогдож болно. Энэ нь хүлээх хугацаа биш бөгөөд Ерөнхийлөгчийн сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хамаарахгүй юм.
- 3.4 Гүйцэтгэх Зөвлөлийн бүх гишүүдийн бүрэн эрхийн болон улиран сонгогдох хугацаа нь тэднийг сонгосон Чуулган дуусахад эхлэнэ; гэхдээ тэд сонгогдсон даруйдаа Гүйцэтгэх Зөвлөлийн хуралдаанд зөвлөлдөх эрхтэй оролцож болно. Тэдний бүрэн эрхийн хугацаа нь сүүлчийн ээлжит Чуулганы төгсгөлд дуусгавар болно.
- 3.5 Энэ Дүрэмд хэрэглэсэн “жил” гэдэг үг нь ээлжит хоёр Чуулганы хоорондох хугацааг заана.

#### **4. Сул орон тоо**

- 4.1 Ерөнхийлөгчийн сул орон тооны тухай Хартийн 24-р заалтад өгүүлэх болно.
- 4.2 Бусад албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд /энэ орон тоонд/ ажиллах гишүүнийг ОУОХ-ны дараагийн Чуулганаас шинээр нөхөн сонгоно. Шинээр сонгогдсон гишүүн нь өмнөх гишүүнийхээ бүрэн эрхийн хугацааг дуусгана. Үүний дараа Гүйцэтгэх Зөвлөлийн аль ч албан тушаалд сонгогдох эрхтэй байна.

#### **5. Эрх, үүрэг**

Гүйцэтгэх Зөвлөл ОУОХ-ны өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулж дараах ажил үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

- 5.1 Олимпийн Хартийг мөрдөхөд хяналт тавих
- 5.2 ОУОХ-ны захиргаа, удирдлагын ажлыг бүрэн хариуцах
- 5.3 ОУОХ-ны бүтэц, зохион байгуулалт, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны дотоод журам, дүрмийг батлах
- 5.4 ОУОХ-ны санхүүгийн асуудлыг хариуцаж, жилийн тайлан бэлтгэх
- 5.5 Дүрэм буюу түүний албан ёсны тайлбарт оруулах өөрчлөлтийн тухай Чуулганд илтгэх
- 5.6 ОУОХ-нд сонгуулахаар нэр дэвшиж буй хүмүүсийн нэрсийг ОУОХ-ны Чуулганд танилцуулах
- 5.7 Олимпийн наадмыг зохион байгуулахаар нэрээ дэвшүүлж буй хотуудын саналыг хүлээн авах, тэдгээрийг сонгон шалгаруулах явцад хяналт тавих
- 5.8 ОУОХ-ны хүндэт цол, тэмдгийг тодорхойлж олгох
- 5.9 ОУОХ-ны Чуулганаар хэлэлцэх асуудлыг тодорхойлно;
- 5.10 Ерөнхийлөгчийн саналын дагуу Ерөнхий захирал болон Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох эсвэл чөлөөлнө. Тэднийг тушаал дэвшүүлэх, эсвэл арга хэмжээ авах, цалинжуулах тухай шийдвэрийг Ерөнхийлөгч гаргана;
- 5.11 ОУОХ-ны архив, бичиг баримтыг хадгалах
- 5.12 Олимпийн Хартийг зохих ёсоор нь биелүүлэх, Олимпийн наадмыг зөв зохион байгуулахад шаардагдах баримт бичгийг хамгийн тохиромжтой гэж үзэх хэлбэрээр (тогтоол, дүрэм, норм, удирдамж, үндсэн чиглэл, зааварчилга гэх мэт) үйл ажиллагаанд мөрдүүлнэ;

5.13 Чуулганаас даалгасан өөр бусад үүргийг биелүүлнэ.

Гүйцэтгэх Зөвлөл нь Ерөнхийлөгчийн санаачлагаар буюу түүний олонхи гишүүдийн хүсэлтээр хуралдана.

### **Хорин дөрөв. Ерөнхийлөгч**

1. ОУОХ Ерөнхийлөгчийг өөрийн гишүүдийн дотроос нууц санал хураалтаар найман жилээр сонгох бөгөөд түүнийг нэг удаа дөрвөн жилээр улируулан сонгоно. Сонгууль болох тухайн Чуулган эхлэхээс гурван сарын өмнө нэр дэвшигчдийн тухай мэдэгдэнэ.
2. Доорх 3-р зүйлд зааснаас бусад тохиолдолд Ерөнхийлөгчийг Олимпиадын хугацааны хоёр дахь жилд болох Чуулганаар сонгоно.
3. Хэрэв Ерөнхийлөгч үүргээ биелүүлж чадахгүй байвал тэргүүн Дэд ерөнхийлөгч нь ОУОХ-ны Чуулганаар шинэ Ерөнхийлөгчийг сонгох болтол түүнийг орлох болно. Шинэ Ерөнхийлөгч нь өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг дуусгана. Үүний дараа тэрхүү Ерөнхийлөгч дээрх 1-р зүйлд заасны дагуу дахин сонгогдох эрхтэй байна.
4. Ерөнхийлөгч ОУОХ-ны бүхий л арга хэмжээг даргалах бөгөөд тус байгууллагыг байнга төлөөлж байх болно.
5. Ерөнхийлөгч байнгын эсвэл шаардлагатай тохиолдолд тусгай комисс, ажлын хэсгүүдийг байгуулж тэдний ажил үүргийг тодорхойлох бөгөөд гишүүдийг нь томилно. Эдгээр комисс, ажлын хэсгүүд үүргээ гүйцэтгэж дууссан гэж үзвэл Ерөнхийлөгч тэдгээрийг татан буулгах шийдвэр гаргана. ОУОХ-ны Ерөнхийлөгчийн зөвшөөрөлгүйгээр комисс, ажлын хэсгүүд хуралдах эрхгүй. Ерөнхийлөгч өөрийн албан тушаалын дагуу бүх комисс, ажлын хэсгийн гишүүн байх бөгөөд тэдгээрийн хуралд оролцохдоо давуу эрх эдлэнэ.

### **Тамирчдын комисс**

Тамирчдын комиссын гишүүд нь гол төлөв Олимпийн наадамд оролцсон тамирчдаас сонгогдсон байна. Сонгуулийг зуны болон өвлийн Олимпийн наадмыг тохиолдуулан ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс баталсан зааврын дагуу, Тамирчдын комисстэй зөвлөлдөж, мөн сонгууль болох тухайн Олимпийн наадам эхлэхээс нэг жилийн өмнө ОУСХолбоод, ҮОХороодтой харилцан ажилласны үндсэн дээр явуулна.

### **Хорин тав. ОУОХ-ны Ёс зүйн комиссоос авах арга хэмжээ, хүлээлгэх шийтгэл**

1. ОУОХ-ны Ёс зүйн комисс нь Олимпийн Хартид өгүүлсэн эрхэм зүйл хийгээд зарчимд тулгуурласан ёс зүйн зарчмын баримтлал, мөн ёс зүйн дүрмийг

тодорхойлох, тэдгээрийг улам боловсронгуй болгох эрхтэй байна. Түүнээс гадна эдгээр ёс зүйн зарчмыг үл хүндэтгэх, мөн ёс зүйн дүрмийг зөрчих явдалтай холбогдсон гомдлыг судлах ба хэрэв шаардлагатай бол шийтгэл хүлээлгэх тухай саналыг ОУОХ-ны Гүйцэтгэл Зөвлөлд оруулна.

2. Чуулган, Гүйцэтгэх Зөвлөл, сахилга батын комиссоос дараах арга хэмжээ авах буюу шийтгэл хүлээлгэж болно. Үүнд:

2.1 Олимпийн хөдөлгөөний хүрээнд:

2.1.1 ОУОХ-ны гишүүд, насан туршийн Ерөнхийлөгч, хүндэт гишүүд, өргөмжлөлт гишүүдийн хувьд:

- а) Гүйцэтгэх Зөвлөлөөс анхааруулж сануулга өгөх;
- б) тухайн хүний гишүүнчлэлтэй холбогдсон бүхий л эсвэл зарим эрх мэдэл, ажил үүргийг нь Гүйцэтгэх Зөвлөлөөс тодорхой хугацаагаар түр түтгэлзүүлэх.

ОУОХ-ны эрх ашгийг хохироож болзошгүй явдал гаргасан ОУОХ-ны гишүүд, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүд, өргөмжлөлт гишүүдэд шийтгэл хүлээлгэж болно.

Дээрх арга хэмжээ, шийтгэлийг хослуулан хэрэглэж болно.

Сахилга батын зөрчлийг авч хэлэлцсэний дараа холбогдох гишүүн, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүн буюу өргөмжлөлт гишүүний гишүүнчлэлтэй холбогдсон бүхий л эсвэл зарим эрх мэдэл, ажил үүргийг Гүйцэтгэх Зөвлөлийн шийдвэрээр түтгэлзүүлж болно.

ОУОХ-ны гишүүн, насан туршийн Хүндэт Ерөнхийлөгч, хүндэт гишүүн буюу өргөмжлөлт гишүүнээс хасах асуудлыг Хартийн 20.3.7 болон 20.3.8-д дурдсан заалтын дагуу шийдвэрлэнэ.

2.1.2 ОУ-ын Спорт Холбоодын тухайд:

- а) Олимпийн наадмын хөтөлбөрөөс хасах нь:
  - Спортын төрөл (Чуулган);
  - Спортын салбарласан төрөл /жин, зай г.м/ (Гүйцэтгэх Зөвлөл);
  - Уралдаан тэмцээн (Гүйцэтгэх Зөвлөл);
- б) хүлээн зөвшөөрснийг цуцлах;

2.1.3 ОУСХ-дын зөвлөлүүдийн тухайд:

- хүлээн зөвшөөрснийг цуцлах (Чуулган);

2.1.4 Үндэсний Олимпийн Хороодын тухайд:

- а) Олимпийн наадамд оролцох тамирчдыг мэдүүлэх эрхийг хасах (Гүйцэтгэх Зөвлөл);
- б) Гишүүнээс түр түтгэлзүүлэх (Гүйцэтгэх Зөвлөл); ийм тохиолдолд Гүйцэтгэх Зөвлөл тухайн ҮОХ болон түүнд харъяалагдах тамирчдын хувьд ямар үр дагавартай байхыг тус тусад нь тодорхойлно;
- в) Хүлээн зөвшөөрснийг түр буюу бүрмөсөн цуцлах (Чуулган); хүлээн зөвшөөрснийг бүрмөсөн цуцлах тохиолдолд ҮОХ нь Олимпийн Хартийн дагуу олгогдсон бүх эрхээ алдана;
- г) өөрийн улсад Чуулган эсвэл Олимпийн их хурал зохион байгуулах эрхээ алдах (Чуулган);

#### 2.1.5 ҮОХ-дын холбоодын үйл ажиллагааны тухайд:

- хүлээн зөвшөөрснийг цуцлах (Чуулган);

#### 2.1.6 Олимпийн наадмыг зохион байгуулагч хот, Зохион Байгуулах Хороо ба ҮОХ-ны үйл ажиллагааны тухайд:

- Олимпийн наадам зохион байгуулах эрхээ хасуулах (Чуулган) гэх зэрэг арга хэмжээ авч болно.

### 2.2 Олимпийн наадмын хүрээнд :

#### 2.2.1 Уралдаан тэмцээнд ганцаарчлан оролцогчид, багуудын тухайд :

- Олимпийн наадамд оролцохыг түр хугацаагаар эсвэл бүрмөсөн зөвшөөрөхгүй байх ;
- Уралдаан тэмцээнээс хасагдах, амжилт нь хүчингүй болсон тохиолдолд Олимпийн Хартид заасны дагуу авсан медаль, дипломыг нь ОУОХ-нд буцааж өгөх. Түүнээс гадна Олимпийн наадмын аль нэг өөр төрлийн уралдаан тэмцээнээс хасагдсан эсвэл амжилт нь хүчингүй болсон тамирчин буюу багийг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлийн шийдвэрээр байр эзлүүлэхгүй тохиолдолд олгосон медаль, дипломыг ОУОХ-нд буцааж өгөх (Гүйцэтгэх Зөвлөл);

#### 2.2.2 Төлөөлөгчдийн ахлагч, албаны хүмүүс, төлөөлөгчдийн аль ч гишүүд, мөн шүүгчид, шүүгчдийн зөвлөлийн гишүүдийн хувьд:

- Олимпийн наадамд оролцох эрхийг түр буюу бүрмөсөн түтгэлзүүлэх эсвэл хасах (Гүйцэтгэх Зөвлөл)

#### 2.2.3 Наадамд оролцох эрх авсан бусад хүмүүсийн хувьд:

- нэвтрэх эрхийг нь хасах (Гүйцэтгэх Зөвлөл)

- 2.2.4 ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөл сахилга батын комиссоор дамжуулан эрх мэдлээ хэрэгжүүлж болно.
- 2.2.5 Олимпийн наадмын хүрээнд гаргасан аливаа шийдвэрийг тухайн наадмын хаалтын ёслолын ажиллагаа болсон өдрөөс хойш гурван жил өнгөрсний дараа дахин авч хэлэлцэхгүй.
3. Аливаа арга хэмжээ авах, шийтгэл хүлээлгэхээс өмнө ОУОХ-ны эрх мэдэл бүхий байгууллагаас сануулга өгч болно.
4. Аливаа хувь хүн, баг эсвэл хуулийн этгээд нь тэдэнд арга хэмжээ авах эсвэл шийтгэл хүлээлгэхтэй холбогдуулан ОУОХ-ны эрх мэдэл бүхий байгууллагад учрыг нь тайлбарлаж үг хэлэх эрхтэй юм. Тухайлбал юунд буруутгагдаж байгаагаа мэдэх, асуудлыг хэлэлцэхэд өөрийн биеэр байлцах, мөн өөрийгөө өмгөөлөх үндэслэлийг бичгээр гаргах эрхтэй байна.
5. Чуулган, Гүйцэтгэх Зөвлөлийн эсвэл сахилга батын комиссын шийдвэрээр оноосон аливаа арга хэмжээ буюу хүлээлгэж буй шийтгэлийн тухай холбогдох талд бичгээр мэдэгдэнэ.
6. Эрх мэдэл бүхий байгууллага өөр шийдвэр гаргатал тэрхүү арга хэмжээ буюу шийтгэл нь хүчин төгөлдөр хэвээрээ байх болно.

### **Хорин зургаа. Хурал чуулганы дэг журам**

#### **1. Ердийн журам**

- 1.1 Ерөнхийлөгч, эзгүй үед орлож ажиллах тэргүүн Дэд ерөнхийлөгч нь Чуулган, Гүйцэтгэх Зөвлөлийн хурлыг удирдана. Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчид байхгүй үед тэднийг орлож ажиллах Гүйцэтгэх Зөвлөлийн ахлах гишүүн нь даргын үүрэг гүйцэтгэнэ.
- 1.2 Чуулган хуралдуулахад ОУОХ-ны нийт гишүүдийн тал хувь дээр нэг гишүүн байхад хангалттай байна. Гүйцэтгэх Зөвлөлийн хурлыг хуралдуулахад найман гишүүн байх шаардлагатай.
- 1.3 Шийдвэрийг олонхийн саналаар батлана; гэхдээ Үндсэн зарчим болон Хартид аливаа өөрчлөлт оруулахад Чуулганд оролцож буй ОУОХ-ны гишүүдийн гуравны хоёрын олонхийн санал авах хэрэгтэй (олонхи гэдэг нь гучаас доошгүй гишүүнтэй байх ёстой). Чуулганаас өөр шийдвэр гаргаагүй тохиолдолд өөрчлөгдсөн Харти, албан ёсны тайлбар нь нэн даруй хүчин төгөлдөр болно.

Чуулганаар хэлэлцэх асуудалд ороогүй зүйлийг гишүүдийн гуравны нэгийн саналаар эсвэл хурлын даргын шийдвэрээр авч хэлэлцэж болно.

- 1.4 Гишүүн тус бүр нэг санал өгөх эрхтэй байна. Түдгэлзсэн болон бөглөөгүй эсвэл хүчингүй болсон хуудсыг олонхийн саналын тоонд

оруулахгүй. Хэн нэгний өмнөөс төлөөлж санал өгөхийг зөвшөөрөхгүй. Нууц санал хураалтыг хурлын даргын шийдвэрээр эсвэл хуралд оролцож буй гишүүдийн дөрөвний нэгийн хүсэлтээр явуулна. Санал адил хувьтай байх тохиолдолд хурлын даргын санал шийдвэрлэх санал болно.

1.5 Дээрх 1.3, 1.4-д дурдсан заалтыг хувь хүн , зохион байгуулагч хотын сонгуулийн тухайд адил мөрдөнө. Гэхдээ зөвхөн хоёр нэр дэвшигч байвал илүү олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ.

1.6 ОУОХ-ны гишүүн дараах тохиолдолд санал хураалтанд оролцохоос түдгэлзэх ёстой. Үүнд:

а) тухайн гишүүний харъяалагдах улс оронд оршдог хот Олимпийн наадам зохион байгуулахаар нэрээ дэвшүүлсэн тохиолдолд хотыг Олимпийн наадам зохион байгуулагчаар сонгох санал хураахад;

б) Чуулган, Олимпийн их хурал болон өөр бусад хуралдаан, арга хэмжээг зохион явуулахаар нэрээ дэвшүүлсэн хот нь тухайн гишүүний харъяалагдах улс оронд оршдог бол түүнийг сонгон шалгаруулах санал хураалт болоход;

в) ОУОХ-ны гишүүнд нэр дэвшигч нь тухайн гишүүний харъяалагдах орны иргэн байх ба түүнийг сонгох санал хураалт болоход;

г) ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлд буюу өөр аль нэгэн албан тушаалд нэр дэвшигч нь тухайн гишүүний харъяалагдах орны иргэн байх, түүнийг сонгох санал хураахад;

д) Гишүүний харъяалагдах улс оронтой эсвэл тэр орны ҮОХ-той холбогдсон өөр бусад асуудлаар санал хураахад оролцох ёсгүй.

Хэрэв эргэлзээтэй байвал тухайн гишүүнийг санал хураалтанд оролцож болох эсэхийг хурлын дарга шийдвэрлэнэ.

1.7 ОУОХ-ны Ерөнхийлөгч бүх сонгуулийн журмыг тогтооно.

1.8 Олимпийн Хартид тусгагдаагүй ОУОХ-ны Чуулгантай холбогдсон журам, дэгийн аливаа асуудлаар хурлын дарга шийдвэр гаргана.

1.9 Хурлын дарга Чуулган хаасныг мэдэгдэнэ.

## **2. Яаралтай үед мөрдөх журам**

2.1 Яаралтай үед Ерөнхийлөгч эсвэл Гүйцэтгэх Зөвлөл ОУОХ-ны гишүүдээс захидлаар санал авах тогтоолын төслийг санал болгож хариу өгөх хугацаа зааж болох юм. Хэрэв заасан хугацаанд бичгээр ирүүлсэн саналын тоо нь нийт гишүүдийн тал хувь дээр нэмэх нэг саналаас доошгүй байвал, мөн тогтоолыг дэмжсэн санал нь олонхийн тоонд хүрсэн байвал тогтоолыг ийнхүү батлана. Үр дүнг ОУОХ-ны

гишүүдэд тэр даруй бичгээр мэдэгдсэн байх ёстой. Саналыг тоолоход тэдгээр нь хүчин төгөлдөр эсэх талаар эргэлзээ гарвал, тухайлбал шуудан саатсан аль эсвэл өөр бусад тодорхой шалтгаан байвал, мөн нэг буюу хэд хэдэн санал үнэхээр хүчин төгөлдөр байна уу гэдэг талаар эргэлзээтэй байвал тийм саналыг тооцох эсэхийг Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.

2.2 Чуулган эсвэл Гүйцэтгэх Зөвлөлөөр шийдвэрлэж арга хэмжээ авах боломжгүй байвал ОУОХ-ны Ерөнхийлөгч дангаараа шийдвэр гарган арга хэмжээ авч болно. Гагцхүү шийдвэрийг эрх мэдэл бүхий байгууллагаар батлуулах ёстой.

2.3 Яаралтай үед мөрдөх энэ журамтай холбогдсон тогтоол, шийдвэр бусад арга хэмжээ нь Олимпийн Хартид өөрчлөлт оруулах асуудалд хамааралгүй байна.

### **Хорин долоо. Албан ёсны хэл**

1. ОУОХ-ны албан ёсны хэл нь франц, англи хэл байна.
2. ОУОХ-ны бүх Чуулганы үеэр герман, испани, орос болон араб хэлээр зэрэг орчуулга хийгдэх ёстой.
3. Олимпийн Харти болон ОУОХ-ны бусад баримт бичгийн франц, англи эх зөрүүтэй байх тохиолдолд хэрэв энэ талаар тодорхой заалт хийгдээгүй бол франц хэлээр үйлдсэнийг нь баримтална.

### **Хорин найм. ОУОХ-ны хөрөнгө санхүү**

1. ОУОХ үүрэг зорилтоо биелүүлэхийн тулд бэлэг, өв хөрөнгө авах, мөн хөрөнгө санхүүгийн өөр эх үүсвэрийг хайж болно. ОУОХ өөрийн үйл ажиллагаатай холбогдсон эрх, үүний дотор телевизийн нэвтрүүлгийн эрхийг ашигласнаас, мөн Олимпийн наадмыг зохион явуулах зэргээс орлого олж болно.
2. Телевизийн нэвтрүүлгийн эрх олгосноос олох орлогын тодорхой хэсгийг ОУСХ-дод, ҮОХ-дод, үүний дотор “Олимпийн эв санааны нэгдэл” болон Олимпийн наадмыг ЗБХ-д хуваарилан өгч болно.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ**

### **Олон улсын спортын холбоод /ОУСХ/**

### **Хорин ес. ОУСХ-дыг хүлээн зөвшөөрөх нь**

ОУОХ олимпийн хөдөлгөөнд тус дөхөм үзүүлэх үүднээс дэлхийн түвшинд нэг буюу хэд хэдэн спортын төрлийг удирддаг, мөн эдгээр спортын төрлүүдийг үндэсний хэмжээнд хөгжүүлэн удирдаж буй байгууллагуудыг эгнээндээ багтаасан олон улсын төрийн бус байгууллагуудыг ОУСХолбоод хэмээн хүлээн зөвшөөрч болно. Хүлээн зөвшөөрүүлэхийн тулд дээрх байгууллагууд

сэргээшийн эсрэг олон улсын дүрмийг зөвшөөрч түүнийг хэрэгжүүлэх ёстой. ОУОХ-гоор шинээр хүлээн зөвшөөрүүлсэн ОУСХ-дыг хоёр жилээр эсвэл ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөс тогтоосон хугацаанд түр хүлээн зөвшөөрнө. Энэ хугацаа дуусахад тухайн ОУСХ-г хүлээн зөвшөөрснөө ОУОХ-ноос бичгээр тодорхой баталж өгөөгүй бол түүнийгээ шууд цуцалсан гэж үзнэ. ОУСХ-дын Олимпийн хөдөлгөөнд гүйцэтгэх үүргийн тухайд тэдгээрийн дүрэм, тогтоосон журам ба үйл ажиллагаа нь Олимпийн Хартид нийцсэн байх ёстой. Дээр дурьдсан зүйлийг мөрдөхийн зэрэгцээ ОУСХ тус бүр нь өөрийн эрхэлсэн спортыг удирдахдаа бие даасан, чөлөөт байдалтай байна.

### **Гуч. ОУСХ-дын үүрэг**

1. *ОУСХолбоод дараах үүрэг хүлээнэ. Үүнд:*
  - 1.1 Олимпийн үзэл санаанд нийцүүлэн тухайн спортын төрлийн дүрмийг боловсруулан гаргаж түүнийг биелүүлэх, мөрдлөг болгох;
  - 1.2 Өөрийн эрхэлсэн спортын төрлийг дэлхий нийтэд хөгжүүлэх;
  - 1.3 Олимпийн Хартид тодорхойлсон зорилтуудыг хэрэгжүүлэхэд, ялангуяа олимпизм болон олимпийн боловсролыг түгээн дэлгэрүүлэх замаар хувь нэмэр оруулах;
  - 1.4 Олимпийн Хартид нийцүүлэн Олимпийн наадмын уралдаан тэмцээнд оролцох өөрийн шалгуурыг тогтоох ба түүнийг ОУОХ-гоор батлуулах;
  - 1.5 Олимпийн наадмаар болон ОУОХ-ны ивээлийн дор явагдах өөрийн эрхэлсэн спортын төрлийн уралдаан тэмцээнийг удирдан зохион байгуулах, техникийн хяналтыг хариуцах;
  - 1.6 “Олимпийн эв санааны нэгдэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх;
2. *ОУСХолбоод нь дараах зүйлийг хийж болно. Үүнд:*
  - 2.1 ОУОХ-нд хандаж Олимпийн Харти ба Олимпийн хөдөлгөөн, Олимпийн наадмыг зохион байгуулах, тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдсон асуудлаар өөрсдийн саналыг нэгтгэн илтгэх
  - 2.2 Олимпийн наадмыг зохион байгуулах нэр дэвшигчдийн талаар, ялангуяа нэрээ дэвшүүлж буй хотуудын техникийн нөхцөл боломжийн талаар санал бодлоо илэрхийлэх;
  - 2.3 Олимпийн их хурлын бэлтгэл хийхэд хамтран ажиллах;
  - 2.4 ОУОХ-ны хүсэлтээр ОУОХ-ны комиссуудын үйл ажиллагаанд оролцох.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Үндэсний олимпийн хороод (ҮОХ-д)

#### Гучин нэг. ҮОХ-дын зорилт, үүрэг

1. Үндэсний Олимпийн Хороодын зорилт бол өөрийн улс оронд олимпийн хөдөлгөөнийг Олимпийн Хартийн дагуу хөгжүүлэн хамгаалах явдал юм.
2. *Үндэсний олимпийн хороод нь:*
  - 2.1 Олимпизмийн үндсэн зарчмуудыг улс үндэстнийхээ хэмжээнд, спортын үйл ажиллагааны хүрээнд сурталчлах, мөн ерөнхий боловсролын болон их, дээд сургуулийн биеийн тамир, спортын сургалтын хөтөлбөрт олимпизмийн үзэл санааг тусган дэлгэрүүлэхэд тус нэмэр болох ёстой. Жишээ нь: Олимпийн боловсрол олгоход чиглэгдсэн байгууллагуудыг бий болгоход дөхөм үзүүлнэ. Тухайлбал: Үндэсний олимпийн академи, Олимпийн музей байгуулах, олимпийн хөдөлгөөнд хамаарал бүхий соёл боловсролын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд санаа тавьж ажиллана.
  - 2.2 Олимпийн Хартийг өөрийн улс оронд мөрдүүлэх
  - 2.3 Их спорт болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;
  - 2.4 Спортын удирдах ажилтан бэлтгэхэд туслах, сургалт дамжаа зохион байгуулах, эдгээр сургалт нь олимпизмийн үндсэн зарчмыг сурталчлахад тус нэмэр болоход чиглэгдэнэ;
  - 2.5 Спортод ямарваа нэгэн ялгаварлан гадуурхах ба хүчирхийлэх явдалтай тэмцэх нь өөрийн үүрэг гэж үзнэ.
  - 2.6 ОУОХ, ОУСХ-доос хориглосон эм, эмийн бэлдмэлийг хэрэглэх явдалтай тууштай тэмцэж энэ ажилд өөрийн улс орны эрх мэдэл бүхий байгууллагуудыг татан оролцуулж эмнэлэгийн хяналтын ажлыг аль болох боломжтой нөхцлөөр хангах.
3. ҮОХороод нь Олимпийн наадам болон ОУОХ-ны ивээлийн дор зохион явуулах бүс, тив, дэлхийн хэмжээний спортын олон төрлийг хамарсан уралдаан тэмцээнд өөрийн улс орныг төлөөлөх онцгой эрхтэй байна. Түүнээс гадна ҮОХ бүр тамирчдаа Олимпийн наадамд оролцуулах ёстой;
4. ҮОХороод Олимпийн наадмыг өөрийн оронд зохион байгуулахаар нэр дэвшүүлж болох хотын тухайд саналаа хэлэх бүрэн эрхтэй.
5. ҮОХороод холбогдох төрийн байгууллагуудтай харилцан уялдаатай хамтран ажиллахад үйл ажиллагаагаа чиглүүлж, мөн спортыг бүх шатанд хөгжүүлэх хөтөлбөрүүдийг боловсруулахад үр дүнтэй хувь нэмэр оруулах ёстой. Спорт нь боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг болон нийгмийн

салбарт тус дэм болдог учир Үндэсний олимпийн хороод өөрийн зорилтод хүрэхийн тулд улсын байгууллагуудын дэмжлэг авч байх нь зүйтэй. Гэхдээ ҮОХороод өөрийн бие даасан байдлыг хадгалж Олимпийн Хартийг мөрдөж ажиллахад тэдэнд саад болж болох улс төр, шашин шүтлэг, эдийн засгийн зэрэг аливаа дарамт шахалтыг няцааж байх ёстой.

6. Үндэсний олимпийн хороод дараах эрхтэй байна. Үүнд:
  - 6.1 Олимпийн Харти болон олимпийн хөдөлгөөнд хамаарах, тухайлбал Олимпийн наадмыг зохион байгуулах талаар өөрийн саналаа боловсруулж ОУОХ-нд тавих;
  - 6.2 Олимпийн наадмыг зохион байгуулах нэр дэвшигчдийн талаар санал бодлоо илэрхийлэх;
  - 6.3 Олимпийн их хурлын бэлтгэл хийхэд хамтран ажиллах
  - 6.4 ОУОХ-ны хүсэлтийн дагуу ОУОХ-ны комиссуудын үйл ажиллагаанд оролцох;
7. ОУОХ өөрийн хэлтэс, салбаруудаар дамжуулан эсвэл Олимпийн эв санааны нэгдлийн шугамаар ҮОХ-дын зорилтыг биелүүлэхэд тэдгээрт туслана.
8. ҮОХороод зорилтоо биелүүлэхдээ төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж болно. Ингэхдээ Олимпийн Хартид харш аливаа үйл ажиллагаанд хэзээ ч нэгдэн оролцох ёсгүй.
9. Үндэсний Олимпийн Хороо Олимпийн хартийг зөрчсөн тохиолдолд ОУОХ нь хориг арга хэмжээ авах бөгөөд тухайн асуудлаар тайлбар сонссоны дараа хоригийг зогсоох буюу цуцалж болно. Үүнд:
  - 9.1 Хэрэв тухайн оронд мөрдөгдөж буй хууль тогтоомж эсвэл энэ улсын спортын буюу өөр бусад байгууллагын үйлдэл нь ҮОХ-ны үйл ажиллагаанд саад учруулж байвал;
  - 9.2 Хэрэв тухайн оронд мөрдөгдөж буй хууль тогтоомж эсвэл энэ улсын аль нэгэн байгууллагын үйлдэл нь ҮОХ-нд харъяалагдах үндэсний спортын холбоод буюу бусад байгууллагууд хүсэл эрмэлзлээ илэрхийлэхэд саад учруулж байгаа бол дээрх заалтыг биелүүлнэ.

### **Гучин хоёр. ҮОХ-дын бүрэлдэхүүн\***

1. Үндэсний Олимпийн Хороод нь зохион байгуулалт, бүтцээс үл шалтгаалан бүрэлдэхүүндээ:
  - 1.1 Хэрэв тухайн улс оронд ОУОХ-ны гишүүд байвал тэднийг бүрэлдэхүүндээ оруулна. Эдгээр гишүүд ҮОХ-ны чуулганы санал хураалтанд оролцох эрхтэй байна. Түүнээс гадна Хартийн 20-р заалтын 2.2.1 болон 2.2.4-д

заасны дагуу тухайн улс оронд байгаа ОУОХ-ны гишүүд албан тушаалаараа ҮОХ-ны гүйцэтгэх байгууллагын гишүүн байж санал өгөх эрхтэй юм.

- 1.2 Олимпийн наадмын хөтөлбөрт багтах спортын төрлүүдийг эрхлэн удирдах ОУСХ-дын гишүүн бүх үндэсний холбоод (таваас цөөнгүй) эсвэл тэдний томилсон төлөөлөгчид ҮОХ-ны гишүүн байна. Эдгээр үндэсний холбоод өөрийн улс оронд болон олон улсын хэмжээнд жинхэнэ спортын үйл ажиллагаа явуулдаг, ялангуяа уралдаан тэмцээн зохион байгуулж тэдгээрт оролцдог, тамирчдад зориулсан сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг гэсэн нотлох баримттай байх хэрэгтэй. ҮОХ олон улсын холбооны удирдлагын дор тухайн спортын төрлийг эрхлэн ажиллах нэг л үндэсний холбоог хүлээн зөвшөөрч болно. Түүнчлэн эдгээр үндэсний холбоод буюу тэдний сонгосон төлөөлөгчид ҮОХ болон түүний гүйцэтгэх байгууллагын санал хураалтанд оролцогчдын олонхийг бүрдүүлэх ёстой.
  - 1.3 Олимпийн наадамд оролцож байгаа буюу их спортоор хичээллэж буй эсвэл, их спортыг орхисон тамирчид, хэрвээ тэдний оролцсон Олимпийн наадмаас эхлэн гурван олимп өнгөрсөн тохиолдолд тэд дээрх сонгуульт албаа орхих ёстой.
2. Үндэсний олимпийн хороодын гишүүнээр:
- 2.1 ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн боловч Олимпийн наадмын хөтөлбөрт ороогүй спортын төрлүүдийг эрхлэх ОУСХ-дын гишүүн үндэсний холбоод;
  - 2.2 Спортын олон төрлийг хамарсан цогцолбор болон спортын чиглэлийн байгууллагууд, тэдгээрийн төлөөлөгчид, мөн ҮОХ-ны үр нөлөөг дээшлүүлэхэд тус дөхөм болох эсвэл спорт болон олимпизмийг хөгжүүлэхэд гарамгай хувь нэмэр оруулсан тухайн улс орны иргэд байна.
3. Олимпийн наадамтай холбоотой асуудлыг хэлэлцэж санал хураахад зөвхөн ҮОХ-ны гүйцэтгэх байгууллагын болон Олимпийн наадмын хөтөлбөрт орсон спортын төрлүүдийг эрхлэн удирдах олон улсын спортын холбоодын гишүүн үндэсний холбоодын саналыг тооцно.
  4. Засгийн газар буюу төрийн бусад байгууллагууд ҮОХ-ны гишүүдийг томилохгүй. Гэхдээ ҮОХ эдгээр байгууллагын төлөөлөгчдийг өөрийн үзэмжээр гишүүнээрээ сонгох шийдвэр гаргаж болно.
  5. ҮОХ нь анх байгуулагдаж, ийм нэрээр нэрлэгдэхээсээ өмнө тухайн байгууллага ОУОХ-гоор хүлээн зөвшөөрөгдөх ёстой. Ингэж хүлээн зөвшөөрөхдөө ОУОХ нь тухайн улсын хууль, холбогдох журам, тэдгээрийг үндэслэгч төв байгууллагын тогтвортой байдал нь ҮОХ-ны эрх зүйд нийцэж буй зэргийг харгалзана.

### **Хартийн 31, 32-т өгөх албан ёсны тайлбар**

1.

- 1.1 ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлэхийн тулд гишүүнд элсэх гэж буй ҮОХ Хартийн 32-т заасан бүх болзлыг биелүүлсэн байна. Тийнхүү ҮОХ өөрийн дүрмийг

франц, англи хэлээр хоёр хувь үйлдэж ОУОХ-нд батлуулахаар явуулна. Гишүүнд элсэх гэж буй ҮОХ өөрийн улсын үндэсний холбоо нь тухайн олон улсын спортын холбооны бүрэн эрхт гишүүн мөн гэдгийг ОУОХ-нд баталж өгөхийг тэрхүү ОУСХ-ноос хүснэ.

- 1.2 ОУОХ-гоор дүрмээ батлуулж түүний гишүүнд элсэх гэж байгаа ҮОХ дүрмийнхээ нэг хувь, хүлээн зөвшөөрч өгөхийг хүссэн өргөдөл, гүйцэтгэх байгууллагынхаа гишүүдийн нэрсийн жагсаалтыг ОУОХ-нд илгээх бөгөөд энэ гурван бичиг баримт үнэн зөв гэдгийг ҮОХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга нар батламжилсан байна.
2. ҮОХ тус бүрийн дүрэм нь Олимпийн Хартид ямагт нийцэж түүний утга санааг тод тусгасан байх ёстой. ҮОХ-ны дүрмийн утга санаа, мөн тайлбарын тухайд эргэлзэх зүйл байвал эсвэл энэ дүрэм нь Олимпийн Хартиас зөрөх тохиолдолд Олимпийн Хартийг мөрдөнө.
3. ОУОХ-гоор батлуулсан дүрэмд өөрчлөлт хийх болбол энэ талаар ОУОХ-нд мэдэгдэн түүнийг баталж өгөхийг хүснэ. Гишүүдийг сонгох, өөрчлөх тухай асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн хурлын тэмдэглэлийн хувийг ОУОХ-нд илгээнэ. Эдгээр бүх баримт бичиг үнэн зөв гэдгийг ҮОХ-ны Ерөнхийлөгч, Ерөнхий нарийн бичгийн дарга нар батламжилсан байна.
4. ҮОХ-ны **бүх гишүүдийн хурлыг** жилд нэгээс доошгүй удаа зарлан хуралдуулна.
5. ҮОХ-ны гүйцэтгэх байгууллагын гишүүд дөрвөөс доошгүй жилд шинэчлэгдэж байх ёстой бөгөөд үүнийг ҮОХ-ны чуулганаар хэлэлцэх асуудалд оруулсан байна.
6. Спортын захиргааны байгууллагад ажиллаж буй хүмүүсээс бусад ҮОХ-ны гишүүд ийм ажил үүрэг гүйцэтгэсний төлөө ямар нэг цалин, шагнал авах ёсгүй. Гэхдээ томилолтоор ажиллахад зарцуулсан замын, байрны болон зайлшгүй шаардлагатай өөр бусад зардлыг нь тэдэнд нөхөн олгож болно.
7. ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн эрхээ түр эсвэл бүрмөсөн цуцлуулсан ҮОХороод нь ОУОХ-ноос тэдэнд олгосон дараах бүх эрхийг алдана. Үүнд:
  - 7.1 “Үндэсний олимпийн хороо” гэж нэрлэгдэх;
  - 7.2 Олимпийн онцлох тэмдгээ ашиглах;
  - 7.3 Олимпийн эв санааны нэгдлийн үйл ажиллагааны үр өгөөжөөс хүртэх;
  - 7.4 ОУОХ-ноос зохиох аль эсвэл түүний ивээл дор явагдах үйл ажиллагаанд оролцох (үүнд бүсийн наадмууд бас багтана);
  - 7.5 Баг , тамирчид, төлөөлөгчид бусад хүмүүсийг оролцуулах
  - 7.6 ҮОХ-дын аливаа эвсэл холбоодод нэгдэх зэрэг болон өөр бусад эрхээ хасуулна.
8. ҮОХороод доорх зорилтуудыг биелүүлнэ. Үүнд:

- 8.1 Олимпийн наадамд болон ОУОХ-ны ивээл дор зохион явуулах бүсийн, тивийн эсвэл спортын олон төрлийг хамруулсан дэлхийн хэмжээний тэмцээнд оролцох өөрийн төлөөлөгчдийг бүрдүүлж, удирдан зохион байгуулна. Холбогдох үндэсний холбоодоос санал болгосон тамирчдыг мэдүүлэх тухай шийдвэр гаргана. Ийм сонголт нь зөвхөн тухайн тамирчны спортын амжилтанд төдийгүй өөрийн орны спортоор хичээллэж буй залуучуудад үлгэр дууриалал болох чадварт нь бас үндэслэсэн байна. ҮОХороод үндэсний холбоодоос санал болгож буй оролцох мэдүүлгийг Олимпийн Хартид бүх талаар нийцүүлэхийг хичээнэ.
- 8.2 Өөрийн төлөөлөгчдийн гишүүдийг хувцас, хэрэгсэл, төхөөрөмж, тээвэрлэлт, байраар хангаж өгөхөд анхаарч ажиллана. Мөн төлөөлөгчдийг гэнэтийн тохиолдлоос хамгаалах (тухайлбал үхэл, тахир дутуу болох явдал, өвчин, эмнэлгийн болон эмийн зардал, гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлага) даатгалын гэрээ хийнэ. Төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд байгаа хүмүүсийн сахилга батын асуудлыг хариуцана.
- 8.3 Үндэсний олимпийн хороод нь өөрсдийн баг, тамирчдыг Олимпийн наадамд болон тэмцээн уралдаан, ёслолын арга хэмжээнд ямар хувцас, форм өмсөх, ямар хэрэглэл ашиглах талаар удирдамж өгөх, шийдвэрлэх онцгой эрхтэй. Энэ онцгой эрх нь тэмцээний үед баг, тамирчдаас хэрэглэх тусгай хувцас хэрэгсэлд хамаарахгүй. Энэ зорилгоор ҮОХ- ноос баталж буй тусгай хувцас хэрэглэл нь зөвхөн спортын төрлөөр хязгаарлагдана. Спортын хувцас, тоног төхөөрөмж нь үйлдвэрлэлийн онцгой шинж чанараас шалтгаалж тамирчдын тоглолтод сайн нөлөө үзүүлэхүйц байх ёстой. Иймэрхүү тусгай хувцасны тухай ҮОХ- дод мэдэгдэж, түүгээр батлагдсан байх ёстой.
9. ҮОХороод дор дурдсан зүйлийг биелүүлэх нь зүйтэй. Үүнд:
- 9.1 Олимпийн хөдөлгөөнийг нийтийн хүртээл болгох зорилгоор Олимпийн өдөрлөг эсвэл долоо хоногийн ажлыг тогтмол зохион явуулж байх (боломжтой бол жил бүр зохиох);
- 9.2 Спорт болон олимпизмийн салбарт соёл урлагийг сурталчлах талаар санаа тавьж ажиллах;
- 9.3 Олимпийн эв санааны нэгдлийн хөтөлбөрүүдэд оролцох;
- 9.4 Бүх талаар бие дааж ажиллах боломжтой байхын тулд санхүүжилтийн эх үүсвэрийг хайх. Сан хөмрөгөө арвижуулахдаа Олимпийн Хартийн заалтыг дагаж, ҮОХ-ны нэр хүнд, бие даасан байдлыг хадгалах талаар анхаарах ёстой.

### **Гучин гурав. Үндэсний спортын холбоод**

Үндэсний спортын холбоод ҮОХ-гоор зөвшөөрүүлж гишүүн нь болохын тулд тодорхой спортын үйл ажиллагаа явуулах, ОУОХ-гоор хүлээн зөвшөөрүүлсэн олон улсын спортын холбооны гишүүн байх, мөн Олимпийн Харти, харъяалсан ОУСХ-ны дүрмийн дагуу ажиллах ёстой.

### **Гучин дөрөв. Улс ба ҮОХ-ны нэр**

1. Олимпийн Хартид байгаа “улс” гэдэг ойлголт нь олон улсын хамтын нийгэмлэгээс хүлээн зөвшөөрсөн тусгаар тогтносон улс гэсэн утгыг илэрхийлнэ.
2. ҮОХ-ны нэр нь түүний нутаг дэвсгэрийн хил хязгаар, улс орных нь өв уламжлалд нийцэж ОУОХ-гоор батлагдсан байх учиртай.

### **Гучин тав. Далбаа, онцлох тэмдэг, дуулал**

ҮОХ өөрийн үйл ажиллагаанд, тухайлбал Олимпийн наадамд ашиглахаар сайшаан батламжилсан далбаа, онцлох тэмдэг, дууллыг ОУОХ-ны Гүйцэтгэх Зөвлөлөөр батлуулах ёстой.